ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

Боловсруулсан: МБСГ, Судалгааны хэлтэс
2015 оны 6 сар

Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн судлаачийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

ОРШИЛ

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар “МЭК” ХХК-тай хамтран Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлын талаарх түүвэр судалгааг 4 дэх удаагаа орон даяар явууллаа. Өмнөх судалгаануудыг 2011, 2012, 2014 онуудад явуулж байсан болно.

Судалгааг явуулахдаа “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг ангилж, түүвэрчлэн хамруулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн салбар, газар зүйн байршил, ажилчдын тоо зэргийг харгалзан үзэж санамсаргүй түүврийн аргаар судалгааны нэгжийг сонгон авлаа.

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийн өнөөгийн байдал, хөгжил, үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс, санхүүжилт болон зардлын байдлыг тодорхойлохыг зорилоо.

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан энэхүү судалгаанд хүн амын тал хувь нь оршин суудаг, ААН-ийн дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотоос 1016, аймгуудын хувьд үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн тоог харгалзан тус бүр 30-50 орчим түүврийг сонгож, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 1991 ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамруууллаа.

Судалгааны мэдээллийг түүвэрлэлтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс санал асуулга бөглүүлэх, ярилцлага авах хэлбэрээр бүрдүүлсэн. Өмнөх судалгаануудын адил ЖДҮ эрхэлдэг хувираа хөдөлмөр эрхлэгч болон аж ахуйн нэгжийн удирдлагын түвшнээс (эзэн, гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, нягтлан бодогч зэрэг гүйцэтгэх удирдлага) судалгааг авсан болно.

Судалгааны ажил нь үндсэн таван бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын зорилго, аргачлал болон түүвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй тусгаж, хоёрдугаар бүлэг буюу ерөнхий мэдээлэл бүлэгт түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэлбэр, үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (насжилт), ажиллагсдын тоо, жилийн борлуулалтын орлогын байдлаар нь ангилж судаллаа.

Гуравдугаар бүлэгт ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын талаар дурдсан бол дөрөвдүгээр бүлэгт бизнесийн ерөнхий орчны талаар буюу макро эдийн засаг, нийгэм улс төрийн байдал, хууль эрх зүй төрийн зохицуулалт, зах зээлийн орчин, дэд бүтцийн хөгжил, ААН-ийн дотоод үйл ажиллагаа болон санхүүжилтийн орчнуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад бэрхшээл болж буй хүндрэлүүдийг тодорхойллоо.

Харин тавдугаар бүлэг буюу зардлын байдалд ЖДҮ эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад гарах зардлын байдлыг тогтоож, ямар зардал ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байгаа талаар авч үзсэн болно.

Эцсийн бүлэгт уг түүвэр судалгаанаас гарсан үр дүнгийн талаарх нэгдсэн дүгнэлт болон цаашид авах арга, хэмжээний талаар танилцууллаа.

Судалгааны дүнг нийслэл хот, аймаг тус бүрээр нь гаргаж хавсралтанд тусгав.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ

Зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн хөгжил, үйл ажиллагааны өнөөгийн байдал, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтанд ашиглах, үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

Санал асуулга авах зорилтот бүлэг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн эзэн/ гүйцэтгэх удирдлага (захирал, гүйцэтгэх, ерөнхий менежер, нягтлан гэх мэт) ба хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байв.

Аргачлал

Судалгааны мэдээллийн санг санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан ЖДҮ-ийн эзэн, гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнаас[1] ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно.

Судалгааны санал асуулгыг бусад орнуудад хийгдсэн ижил төстэй судалгааны санал асуулгууд дээр үндэслэн боловсруулав.

Түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгжийг сонгохдоо ААН-үүдийн байршил, ажиллагсдын тоо болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүйгээр сонголоо. Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа ба дунджийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 5%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх, хамгийн бага хэмжээний түүврийг үүсгэхээр сонголоо[2].

Түүврийн эх олонлогт 2014 оны эцсийн байдлаар Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны Бизнес регистрийн санд[3] бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 59,843 аж ахуйн нэгжүүдийг хамруулаа. Статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг Улаанбаатар хотоос 1000, аймгуудаас 30-50 буюу нийт 1850 байхаар төлөвлөв. Санал асуулгын хариултын чанараас хамааран зарим газраас илүү эсвэл дутуу тооны санал асуулга авах магадлалтай байсан бөгөөд нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс 8%-иар илүү буюу 1,991 түүвэр санамсаргүйгээр сонгов. Санал асуулгад оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийт оролцогчдын 51%-ийг Улаанбаатар хотын, 49%-ийг орон нутгийн ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд хувийн жинг харвал ихэнх аймгуудад 2-3 хувийн хооронд жигд

---

1 ААН-ийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар мэдээлэл өгөх бүрэн боломжтой удирдах албан тушаалтнууд.

2 $\boldsymbol{n = \frac{z^2 S^2 N}{\Delta^2 N + z^2 S^2}}$; n-хамгийн бага түүврийн хэмжээ, z-итгэх интервалд харгалзах критек утга (95%-ийн итгэх түвшинд 1.96-тай тэнцүү байна), s-стандарт хазайлт, N-эх олонлогийн хэмжээЬ Δ- үнэлгээний нарийвчлал.

3 ҮСХ, Статистикийн мэдээ, 2014 он 12 сар.

тархалттайгаар хамрагдав *(Хүснэгт 1.1)*.

Харин идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 59,843 ААН-үүдийн 3.3% нь судалгаанд хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотын 2.7%, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудад 2.5-3.2%, Говьсүмбэр аймгийн 9.9%, бусад аймгуудад 3.1-6.7% нь хамрагдсан байна.

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тоо (*аймаг, нийслэлээр*)

	Үйл ажиллагаа явуулж буй ААН		Судалгаанд хамрагдсан ААН			
	Тоо	Хувийн жин	Төлөв-лөсөн	Авсан	Хувийн жин	Нийт ААН-д эзлэх хувь
Улаанбаатар	37,124	62.04%	1,000	1,016	51.03%	2.74%
Сэлэнгэ	1985	3.32%	30	49	2.46%	2.47%
Орхон	1810	3.02%	40	50	2.51%	2.76%
Дархан-Уул	1,757	2.94%	50	56	2.81%	3.19%
Ховд	1,553	2.60%	50	50	2.51%	3.22%
Увс	1324	2.21%	50	45	2.26%	3.40%
Баян-Өлгий	1,236	2.07%	50	49	2.46%	3.96%
Хөвсгөл	1202	2.01%	40	47	2.36%	3.91%
Дорнод	1111	1.86%	40	53	2.66%	4.77%
Төв	1085	1.81%	50	52	2.61%	4.79%
Өвөрхангай	1,065	1.78%	50	48	2.41%	4.51%
Өмнөговь	1048	1.75%	30	48	2.41%	4.58%
Завхан	970	1.62%	50	46	2.31%	4.74%
Булган	961	1.61%	40	48	2.41%	4.99%
Хэнтий	948	1.58%	30	46	2.31%	4.85%
Архангай	922	1.54%	40	51	2.56%	5.53%
Дорноговь	846	1.41%	20	41	2.06%	4.85%
Баянхонгор	827	1.38%	30	49	2.46%	5.93%
Говь-Алтай	687	1.15%	30	47	2.36%	6.84%
Сүхбаатар	607	1.01%	30	40	2.01%	6.59%
Дундговь	533	0.89%	50	36	1.81%	6.75%
Говьсүмбэр	242	0.40%	50	24	1.21%	9.92%
Нийт	59,843	100%	1,850	1,991	100%	3.33%

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-үүдийн 85% нь 1-9 ажиллагсадтай, 11.8% нь 10-49 ажиллагсадтай, 3.0% нь 50-иас дээш тооны ажиллагсадтай байна (*Хүснэгт 1.2)*. Өмнөх жилтэй харьцуулахад ААН-үүдийн ажилчдын тооны хувьд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1.2 Бүртгэлтэй ААН-ийн тоо, ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг	ААН-ийн тоо	Хувийн жин
1-9	50,932	85.0%
10-49	7,087	11.8%
50-аас дээш	1,824	3.0%
Нийт	59,843	100.0%

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр, үйл ажиллагааны төрөл: Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувийг дотоодын хөрөнгө оруулалттай, худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ХХК-ууд эзэлж байна.

Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, ажиллагсдын тоо: Судалгаанд оролцогчдын тал нь 1-5 жил, үлдсэн нь 5-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай байна.

Аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого: Судалгаанд оролцогчдын дийлэнх нь жилийн 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой бөгөөд үүний талаас илүү нь 10 хүртэлх сая төгрөгийн орлоготой байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү бүлэгт санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаарх ерөнхий мэдээллийг харуулав.

2.1. Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл дийлэнх хэсэг нь буюу 96% нь дотоодын хөрөнгө оруулалттай ААН-үүд эзэлж өмнөх жилүүдийн дүнгээс төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Харин гадаадын хөрөнгө оруулалттай 2%, холимог өмчлөлтэй ЖДҮ эрхлэгчид 3%-ийг эзэлж байна.

Зураг 2.1 ААН-ийн өмчлөлийн хэлбэр (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Судалгаанд оролцсон ААН-үүдээс дотоодын хөрөнгө оруулалттай ЖДҮ эрхлэгч нар түлхүү оролцсон бөгөөд өмнөх судалгаануудтай харьцуулж үзвэл өсөх хандлагатай байхад гадаадын болон холимог өмчлөлтэй ААН-үүдийн оролцоо

буурах хандлагатай болжээ. Сүүлийн жилүүдэд ГШХО эрс буурч, зогсонги байдалд орсноор гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн тоо буурсан нь судалгааны дүнгээс харагдаж байна.

2.2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл

Санал асуулгад оролцогчдын ихэнх нь буюу 61% нь худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 2.2 ААН-ийн үйл ажиллагааны төрөл (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин үйлдвэрлэлийн салбарт 23%, барилгын салбарт 7%, ХАА-н салбарт 7% нь үйл ажиллагаагаа явуулж байна.

2.3.Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа

ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар нь авч үзвэл 10% нь 1 жил хүртэлх, 39% нь 1-5 жил, 26% нь 5-10 жил, 26% нь 10-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2.3 ААН-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Өмнөх судалгааны дүнгүүдээс харахад 1 жил хүртэлх буюу үйл ажиллагаагаа явуулаад удаагүй байгаа ААН-үүд бага оролцдог болох нь харагдаж байна.

2.4. Ажиллагсдын тоо

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 74% нь 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай байгаа нь өмнөх жилүүдийн түвшингээс бага зэрэг өссөн байна. Харин 20% нь 10-49 хүртэлх тооны ажиллагсадтай бол 50-аас дээш тооны ажиллагсадтай ЖДҮ эрхлэгчид нийт оролцогчдын 7%-ийг эзэлж байна.

Зураг 2.4 ААН-ийн ажиллагсдын тоо (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

2.5. Борлуулалтын орлого

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 74% нь жилд 50 сая хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой байна. Үүнээс 10 сая хүртэл болон 10-50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгчид ойролцоо хувьтай байна.

Зураг 2.5 Жилийн борлуулалтын орлого (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

50-500 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгч нийт оролцогсдын 19%-ийг эзэлж байгаа бол 500 саяас 1.5 тэрбум төгрөгийн орлоготой нь 6%-ийг эзэлж байна.

Энэ удаагийн судалгаанд 10 болон 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд өмнөх судалгаануудаас өндөр байгаа бол 50-500 сая төгрөгийн орлоготой ААН-үүдийнх буурч хамгийн бага түвшиндээ хүрсэн байна. Эндээс харахад ААН-үүдийн борлуулалтын орлогын түвшин буурч байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн борлуулалтын орлогыг аймгуудаар ангилан харвал Говь-Алтай, Дундговь зэрэг аймгуудад болон Улаанбаатар хотод 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд хамгийн их хувьтай буюу 80%-иас дээш байхад Завхан, Сэлэнгэ зэрэг аймгуудад хамгийн бага буюу 30%-иас доош байна. Харин эсрэгээрээ Завхан, Сэлэнгэ зэрэг аймгуудад 50-иас дээш сая төгрөгийн орлоготой ААН-үүд дийлэнх хувийг нь эзэлж байна. Хамгийн их буюу 500 саяас 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд Сэлэнгэ, Дархан-Уул зэрэг аймгуудад 10%-иас дээш байна. Энэ нь тухайн бүс нутгийн хүн амын амьжиргааны түвшин, үйлдвэржилт болон бусад онцлогуудаас шалтгаалах боловч судалгааны түүвэрлэлтээс мөн ихээхэн хамааралтай байгаа юм.

Зураг 2.6 Жилийн борлуулалтын орлого, аймгуудаар (*ЖДҮ-ийн хариулсан хувиар*)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

3. ДЭМЖЛЭГ

Энэхүү бүлэгт манай улсад ЖДҮ эрхлэгчдийг ямар төрлийн байгууллагууд дэмжиж байна, тэдгээрээс ямар дэмжлэгүүд үзүүлж байна, мөн цаашид нэн түрүүнд ямар төрлийн арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа талаарх санал асуулгын үр дүнг танилцууллаа.

Дэмжлэг үзүүлж буй байгууллагууд: Энэ удаагийн судалгаагаар ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмжиж буй байгууллагууд нь өмнөх судалгааны үр дүнтэй (2011, 2012 он) ижил арилжааны банкууд байна. Мөн орон нутгийн засаг, захиргаа ЖДҮ эрхлэгчдэд багагүй дэмжлэг үзүүлдэг байна. Харин УИХ, Засгийн газрын хувьд зөвхөн санхүүжилтийн дэмжлэгээс гадна бодлого, үйл ажиллагаанд ЖДҮ эрхлэгчид ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

ДЭМЖЛЭГ

Санал асуулгын дүнгээр ЖДҮ эрхлэгчдийг арилжааны банкууд хамгийн ихээр дэмждэг гэсэн үр дүн гарсан байна. Түүний дараагаар орон нутгийн засаг захиргаа, бусад санхүүгийн байгууллагууд, үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо зэрэг бусад байгууллагууд орсон байна. Харин УИХ болон Засгийн газрын ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж дэмжлэг хамгийн муу гэсэн үр дүнтэй байна *(Зураг 3.1)*.

Зураг 3.1 ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн нийт хэмжээ 2015 оны I улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 19%-иар өсч 2.2 их наяд төгрөгт хүрсэн ба нийт зээлийн өрийн үлдэгдлийн 18%-ийг[4] бүрдүүлж байна.

Зураг 3.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Олон улсын байгууллагуудын хувьд Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой олон төрлийн хөнгөлөлттэй зээл, тусламжийг арилжааны банкуудаар дамжуулан ЖДҮ эрхлэгчдэд олгож байна.

Олон улсын байгууллага болон Засгийн газраас үзүүлж буй санхүүжилтийн дэмжлэг нь арилжааны банкуудаар дамжуулан олгодог тул ЖДҮ эрхлэгчид хамгийн их дэмжлэг үзүүлж буй байгууллагаар арилжааны банкыг нэрлэсэн байх талтай. Түүнчлэн ЖДҮ эрхлэгчид санхүүжилтээ арилжааны банкнаас өөр эх үүсвэрээс олох боломж хомс байдаг нь нөлөөлсөн байж болох юм.

Засгийн газар, олон улсын байгууллага, арилжааны банкууд болон бусад холбогдох байгууллагуудын зүгээс ЖДҮ эрхлэгчдэд голчлон санхүүжилт олгох, татварыг хөнгөвчлөх (татвар, НӨАТ-аас чөлөөлсөн), сургалт, зөвлөгөө явуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг дэмжлэгүүдийг үзүүлж байна.

Шигтгээ 3.1: Засгийн газрын дэмжлэг

Жижиг дунд үйлдвэрийн хөгжил нь улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулдаг бөгөөд төрөөс ЖДҮ-ийг дэмжих нь нийгэм эдийн засгийн чухал асуудлыг шийдвэрлэх нэг арга зам юм.

1. Монгол улсын Засгийн газар ЖДҮ-ийг дэмжих зорилгоор санхүүжилтийн асуудлыг дэс дараатай шийдвэрлэж ирлээ. Тухайлбал, сүүлийн жилүүдэд ЖДҮ эрхлэгчдэд олгож байгаа зээлийн дээд хэмжээ 50 сая төгрөг байсныг 500 сая төгрөгт хүргэн нэмэгдүүлэх, зээлийн хугацаа 3 жил байсныг 5 жил болгож уртасгах, зээлийн хүү 12% байсныг 9% болгож бууруулах зэргээр санхүүжилтийг дэмжих арга хэмжээг авсан байна.

[4] Монголбанк, ЖДҮ-ийн зээлийн тайлан, 2015 оны I улирал.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2009-2012 оны хооронд олгосон хөнгөлөлттэй зээлд 5171 иргэд, ААН хамрагдсанаас 4113 нь үйл ажиллагаагаа өргөжүүлж үлдсэн 1058 нь шинэ төсөл хэрэгжүүлжээ. Уг хөнгөлөлттэй зээлийн үр дүнд нийт 22825 ажлын байр шинээр бий болсон бол 24477 ажлын байрыг хадгалж үлдсэн байна.

2013 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр нийт 490 төслийн 59 тэрбум төгрөгийн зээл олгогдож 4330 ажлын байр шинээр бий болж, 1960 ажлын байр хадгалагдсан байна. Олгогдсон нийт хөнгөлөлттэй зээлийн 28 хувийг хөнгөн үйлдвэрлэлийн, 25 хувийг хөдөө аж ахуйн, 14 хувийг хүнсний салбарт, 10 хувийг нь үйлчилгээний салбарт олгожээ.

Харин сүүлийн хоёр жилийн байдлаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нийт 947 төсөлд 150 тэрбумын төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан хийгээд байна.

2. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээс гадна үйл ажиллагаа явуулах эдийн засгийн таатай орчин бүрдүүлэхийн тулд зарим төрлийн татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ЖДҮ-ийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 он хүртэл чөлөөлсөн.
- Газар тариалан, ойн аж ахуйн зориулалттай болон гурилын үйлдвэр, усалгааны техник төхөөрөмж, үр, бордоо, хорыг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, тэдгээрийг дотоодоо борлуулсан бол 2016 он хүртэл НӨАТ-аас чөлөөлжээ.
- Монгол улсын нутаг дэвсгэр дээр ЖДҮ-ийн зориулалттай тоног төхөөрөмж үйлдвэрлэсэн, борлуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ААН-ийн болон хүн амын албан татвар ногдуулахгүй байхаар шийдвэрлэсэн.
- ЖДҮ-ийн тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд ХАА-н үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50%-иар хөнгөлсөн зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна

3. Хууль эрх зүйн орчны хүрээнд:

- ЖДҮ эрхлэгчид Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор *Зээлийн батлан даалтын сангийн тухай* хуулийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан байна. Тус хуулинд: Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах
- 2013 онд Жижиг, дунд үйлдвэр, хувираа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох “Ажилтай орлоготой, Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг баталсан.
- 2014 онд Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилготойгоор оршино “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” 2014-2016 оны хооронд хэрэгжүүлэхээр баталсан.
- Сангийн яам, Хөдөлмөрийн яам, Төрийн банк 2015 онд “Багцын батлан даалтын гэрээ”-нд гарын үсэг зурсан байна. Батлан даалтын хэмжээний хувьд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл хүсч буй малчид, хувираа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хувьд 5.0 сая төгрөгийн зээлд 80.0 хувь буюу 4.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдэд 10.0 сая төгрөгийн зээлд 8.0 сая хүртэл төгрөг байна. Зээлдэгч батлан даалт гаргуулсны шимтгэлд батлан даасан дүнгийн 1.0 хувьтай тэнцэх төгрөгийг төлөхөөр шийдвэрлэсэн байна.

Дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг аймгуудаар ангилж үзвэл Говь-Алтай аймагт хамгийн муу үнэлгээтэй гарсан байна. Түүний дараагаар Ховд, Булган, Орхон аймгуудын ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг төдийлөн сайнгүй байна *(Зураг 3.3)*.

Зураг 3.3 ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд (аймгуудаар)
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин Хэнтий, Дорноговь, Дорнод аймгуудын хувьд бусад аймгуудтай харьцуулахад ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгийг боломжийн гэж үзсэн байна.

Дүгнэлт

Арилжааны банкууд, орон нутгийн засаг, захиргаа болон олон улсын байгууллагууд, Засгийн газар ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн болон санхүүжилтийн бус (сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа гэх мэт) тодорхой дэмжлэгүүдийг үзүүлж байна. Энэ удаагийн судалгаагаар өмнөх судалгааны үр дүнтэй адилаар ЖДҮ эрхлэгчдэд Арилжааны банкууд хамгийн их дэмжлэг үзүүлдэг гэсэн үр дүн гарлаа. Засгийн газар болон ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нь арилжааны банкуудаар дамжин олгогддог тул ЖДҮ эрхлэгчид арилжааны банкыг хамгийн их дэмжлэг үзүүлдэг гэсэн хандлага өссөн байх талтай. Харин УИХ, Засгийн газрын хувьд зөвхөн санхүүжилтийн дэмжлэгээс гадна бодлого, үйл ажиллагаанд нь ЖДҮ эрхлэгчид ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

4. БИЗНЕСИЙН ОРЧИН

Бизнесийн орчны ерөнхий индекс: ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс нийгэм улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, хууль, эрх зүйн зохицуулалт болон санхүүжилтийн орчин гол хүндрэл учруулж байна. Харин дэд бүтцийн хөгжил, дотоод хүчин зүйлс, зах зээлийн орчин харьцангуй боломжийн буюу бусад орчны индекстэй харьцуулахад бага хүндрэл учруулж байна.

Макро эдийн засгийн нөлөө: Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь төгрөгийн бусад валюттай харьцах ханшийн сулралт, инфляци зэрэг үзүүлэлтүүд хамгийн муу нөлөөг үзүүлсэн байна. Түүнчлэн эдийн засгийн өсөлтийн бууралт болон ГШХО-ын татралт ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байна.

Нийгэм, улс төрийн байдал: Энэ удаагийн санал асуулгын дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд нийгмийн орчны зүгээс ажилгүйдэл, ядуурал их хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. Мөн улс төрийн байдал, хээл хахууль ЖДҮ эрхлэхэд ихээхэн хүндрэл болдог гэж үзжээ.

Хууль эрх зүй, төрийн зохицуулалт: Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчинд өгсөн үнэлгээ судалгаа авч эхэлснээс хойш хамгийн доод түвшиндээ хүрэхэд хуулийн хэрэгжилт сул, төрийн байгууллагын үйлчилгээ хүнд сурталтай байгаа нь голлон нөлөөлжээ.

Зах зээлийн орчин: Судалгааны үр дүнгээс харахад хэрэглэгчдийн худалдан авах чадвар муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж байна. Мөн зах зээлийн багтаамж төдийлөн хангалттай бус байгааг судалгаанд оролцогчид онцолсон байна. Харин технологийн дэвшил, мэдээллийн хүртээмж, зах зээлийн өрсөлдөөнд боломжийн үнэлгээг өгсөн байна.

Дэд бүтцийн хөгжил: ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг боломжийн гэсэн үнэлгээг өгсөн боловч өмнөх судалгаатай харьцуулахад бага зэрэг муудсан дүнтэй байна. Дэд бүтцийн хөгжлийг тодорхойлох үзүүлэлт тус бүрээр харвал зам тээвэр, дулаан усан хангамж бага зэрэг муу үнэлгээтэй гарсан бол цахилгаан түгээлт болон мэдээлэл холбооны хөгжил боломжийн гэсэн үнэлгээтэй байна.

Дотоод үйл ажиллагаа: Дотоод үйл ажиллагааны нөхцөлийн хувьд ажлын байрны шаардлагыг хангах ур чадвартай мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаа нь ЖДҮ эрхлэхэд хамгийн их хүндрэл учруул байна. Мөн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, барилга байгууламжийн хүрэлцээ болон түүхий эдийн олдоц бага зэрэг хүндрэлтэй байна. Харин өрсөлдөх чадвар, тоног төхөөрөмжийн чанарын хувьд ерөнхийдөө боломжийн гэж үзэж байна.

Санхүүжилтийн орчин: ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн орчны зүгээс зээлийн хүү хамгийн их хүндрэл болж байна. Түүний дараагаар зээлийн шимтгэл хураамж, зээлийн хугацаа, барьцаа хөрөнгө, зээлийн хэмжээ болон зээлийн батлан даалт орж байна.

БИЗНЕСИЙН ОРЧИН

4.1 Ерөнхий индекс

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах үндсэн 7 бүлэгт (орчин) хуваан авч үзлээ:

- Макро эдийн засгийн нөлөө
- Нийгэм, улс төрийн байдал
- Хууль эрх зүй, төрийн зохицуулалт
- Зах зээлийн орчин
- Дэд бүтцийн хөгжил
- Дотоод үйл ажиллагааны нөхцөл
- Санхүүжилтийн орчин

Дээрх бүлэг нь нийт 40 хүчин зүйлс[5]-ээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь өөрсдийн хүчин зүйлсийг агуулсан болно.

Санал асуулгын дүнг нэгтгэж, бизнесийн орчны ерөнхий индексийг тооцоход нийгэм улс төрийн орчин **(-0.99),** макро эдийн засгийн орчин **(-0.82),** хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчин **(-0.60)**, санхүүжилтийн орчин **(-0.57)**, зах зээлийн орчин **(-0.40)**, дотоод орчин **(-0.25)**, дэд бүтцийн орчин **(-0.13)** гэсэн үнэлгээтэй гарлаа.

Зураг 4.1 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дээрх үнэлгээнээс харахад манай улсын ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс нийгэм улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, хууль, эрх зүйн зохицуулалт болон санхүүжилтийн орчин гол хүндрэл учруулж байна. Харин дэд бүтцийн хөгжил, дотоод хүчин зүйлс, зах зээлийн орчин харьцангуй боломжийн

[5] 40 хүчин зүйлсийн хувьд маш муу, муу, боломжийн, сайн, маш сайн гэсэн чанарын хариултыг тоон утга руу /-2 оос +2/ индексжүүлэн тооцлоо.

буюу бусад орчны индекстэй харьцуулахад бага хүндрэл учруулж байна.

Бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийг үзүүлэлт тус бүрээр нь үнэлж жагсаахад ЖДҮ эрхлэгчид ажилгүйдэл, ядуурал, улс төрийн байдал, валютын ханш, инфляци болон худалдан авах чадвар бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн хүндрэлтэй байна гэж үзжээ *(Зураг 4.2)*. Үүний дараагаар эдийн засгийн өсөлт, хуулийн хэрэгжилт, зээлийн хүү, төрийн байгууллагын үйлчилгээ, зээлийн шимтгэл хураамж зэрэг үзүүлэлтүүд хүндрэлтэй гэсэн үр дүн гарлаа.

Харин **мэдээлэл холбооны** хөгжил болон цахилгаан түгээлтийг судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид хамгийн сайн гэж дүгнэжээ. Түүнчлэн өрсөлдөх чадвар, тоног төхөөрөмжийн чанар, технологийн дэвшил усан хангамж, түүхий эдийн олдоц зэрэг нь бусад хүчин зүйлстэй харьцуулахад харьцангуй боломжийн гэж үзсэн байна.

Зураг 4.2 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Бизнесийн орчны ерөнхий индексийг аймгуудаар нь авч үзвэл Ховд **(-0.80)**, Говь-Алтай **(-0.80)**, Булган **(-0.73)** аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа эрхлэх орчинг хамгийн хүндрэлтэй гэж үзсэн бол Дорнод **(-0.32)**, Говьсүмбэр **(-0.35)**, Архангай **(-0.35)** аймгуудын хувьд бусад аймгуудтай харьцуулахад боломжийн гэж хариуллаа *(Зураг 4.3)*.

Зураг 4.3 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

4.2 Макро эдийн засгийн нөлөө

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь төгрөгийн бусад валюттай харьцах ханшийн сулралт, инфляцийн өсөлт зэрэг үзүүлэлтүүд хамгийн өндөр сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Харин тэдэнд эдийн засгийн өсөлт удааширсан болон ГШХО буурсан нь бусад эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага сөрөг нөлөөг үзүүлсэн байна (*Зураг 4.4*).

Зураг 4.4 Макро эдийн засгийн нөлөө
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дэлхий банкны 2014 оны тайланд[6] "өндөр инфляци болон төгрөгийн ханшийн уналтаас шалтгаалан **уул уурхайн бус салбарын өсөлт** сүүлийн 4 улирлын турш тасралтгүй саарч байна" гэж тэмдэглэжээ. Мөн нийт эрэлтийн талаас авч үзвэл хувийн салбарын бодит хэрэглээний өсөлт 2011-ээс 2013 онуудад дунджаар 15%-тай байсан бол 2014 онд 9.1%, 2015 оны 1-р улиралд 3.4% болж хумигдсан байна. Эндээс дүгнэхэд нэг талаас импортод тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг манай орны ЖДҮ эрхлэгчдэд **нэрлэсэн ханшийн сулралт болон инфляцийн түвшиний өсөлт нь түүхий эдийн (орц) зардлыг нэмэгдүүлэх дарамтыг** үзүүлж байгаа бол нөгөө талаас **иргэдийн худалдан авалтын бууралт нь бизнесийн идэвхжлийг бууруулах замаар ААН-үүдэд сөрөг нөлөөг** үзүүлж байна.

Эдийн засгийн өсөлт

Манай орны ДНБ-ий бодит өсөлт 2011-ээс 2013 оны хооронд уул уурхайн салбар дахь огцом сэргэлтийг даган 3 жил дараалан 2 оронтой тоонд хадгалагдаж байсан боловч сүүлийн жилд эдийн засаг түүн дотроо уул уурхайн бус салбарын эрч саарснаас үүдэн өсөлт 2014 оны эцэст 7.8%, 2015 оны 1-р улиралд 4.4%-д хүрч бууралд байна *(Шигтгээ 1)*.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 13% нь эдийн засгийн өсөлт бизнес эрхлэх үйл ажиллагаанд нь сайн, 19% нь боломжийн нөлөө үзүүлж байна гэж хариуллаа. Харин нийт судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тал нь буюу 46% нь муу, 22% нь маш муу нөлөө үзүүлсэн гэж дүгнэжээ (*Зураг 4.5*).

[6] Монгол улсын эдийн засгийн тойм 2014 оны 12 дугаар сар

Зураг 4.5 Эдийн засгийн өсөлт



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Эдийн засгийн өсөлт саарч буй өнөөдрийн нөхцөлд ЖДҮ эрхлэгчдийн олонх нь эдийн засгийн өсөлт бизнес эрхлэх үйл ажиллагаанд нь эерэгээр нөлөөлөөгүй гэсэн хариултыг өгснөөс хувийн хэвшлийнхэнд эдийн засагт нүүрлээд буй өнөөгийн хүндрэл хүндээр тусч байгаа нь харагдаж байна.

Шигтгээ 4.1: Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн бодит өсөлт 2011 онд түүхэн хамгийн өндөр түвшин буюу 17.3%-д хүрч байсан боловч энэ нь дотоодын эдийн засгийг дан ганц салбар буюу уул уурхайн салбараас хэт хамааралтай болгосон. Улмаар 2012 оноос манай улсад орж ирэх гадаад валютын урсгал болон гадаад цэвэр активын хэмжээ буурснаас шалтгаалан эдийн засгийн өсөлт жил бүр саарсаар 2014 оны эцэст 7.8%, 2015 оны 1-р улиралд 4.4%-д хүрээд байна.



Эх үүсвэр: УСХ

Энэхүү ГШХО-ын сөрөг нөлөөллийг сааруулах зорилгоор Засгийн газар, Монголбанкны зүгээс 2012-2014 онуудад эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, учирч болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангасны зэрэгцээ эдийн засгийн тэнцвэртэй өсөлтөд дэмжлэг үзүүлсэн.

Хэдийгээр эдийн засгийн өсөлт 2014 онд 7.8%-тай гарсан боловч энэхүү өсөлтийн гол хэсгийг (4.9%) уул уурхайн салбар дангаар бүрдүүлсэн. Түүнчлэн Оюу толгойн эрчимтэй үйлдвэрлэлийг даган тээвэр ба агуулахын салбар хурдацтай өсч 2014 оны нийт өсөлтийн 1.2%-ийг бүрдүүлсэн бол цаг агаарын тааламжтай нөхцөлөөс шалтгаалан ХАА салбар өндрөөр өсч нийт өсөлтийн 1.7%-ийг бүрдүүлсэн байна. Барилга, үйлчилгээ болон аж үйлдвэрийн салбарын өсөлт 2014 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад эрс буурсан.

2015 оны 1-р улирлын байдлаар нийт үйлдвэрлэл огцом буурч эдийн засгийн өсөлт 4.4%-д хүрээд байна. 2014 оноос уул уурхайн бус салбарын эдийн засгийн өсөлт удаашраад байгаа өнөөдрийн нөхцөлд уул уурхайн салбар дахь үйлдвэрлэл буурсан нь нийт эдийн засгийн эрч саарч байгааг илэрхийлж байна. Энэхүү эдийн засгийн 4.4%-ийн өсөлтийн 3.3%-ийг уул уурхай, 1.6%-ийг үйлчилгээ, 0.8%-ийг аж үйлдвэр, -1.9%-ийг бүтээгдэхүүний цэвэр татварын салбар тус тус бүрдүүлж байна.

Инфляци

Судалгаанд оролцогч ЖДҮ эрхлэгчдийн тал буюу 53% нь инфляцийн түвшин бизнес эрхлэхэд муу нөлөөг үзүүлж байна гэж үзсэн бол 24% нь маш муу нөлөөтэй байна гэж хариулжээ.

Харин судалгаанд хамрагдсан **бизнес эрхлэгчдийн 14% нь өнөөдрийн инфляцийн түвшин бизнес эрхлэх үйл ажиллагаанд нь боломжийн, сайн нөлөөг** үзүүлж байна гэсэн хариултыг өгчээ (*Зураг 4.6*).

Зураг 4.6 Инфляцийн түвшин



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Монголбанк инфляцийг 2015 оны эцэст 7%-д, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулсны үндсэн дээр иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засгийн тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн зорилтын хүрээнд мөнгөний уламжлалт болон уламжлалт бус бодлогуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү бодлогын үр дүнд инфляцийн түвшин 2014 оны хагасаас эхлэн тогтвортой буурч, 2015 оны 5-р сарын байдлаар инфляцийн түвшин 7.5%-д хүрсэн нь бизнес эрхлэгчдийн бодит орлогыг үнийн өсөлтөөс хамгаалах сайн нөлөө үзүүлж байна (*Шигтгээ 2*).

Төгрөгийн нэрлэсэн ханш

Төгрөгийн бусад валюттай харьцах ханш суларсан нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь маш муу нөлөөг үзүүлж байна гэж ААН-үүдийн 29% нь, муу нөлөө үзүүлж байна гэж 47% нь хариуллаа. Харин санал асуулганд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 24% нь нэрлэсэн ханшийн өнөөдрийн түвшин нь бизнес эрхлэх үйл ажиллагаанд боломжийн эерэг нөлөөг үзүүлсэн гэж дүгнэжээ (*Зураг 4.7*)

Зураг 4.7 Төгрөгийн ханш



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Эндээс харахад санал асуулгад оролцсон ААН-үүдийн дийлэнх буюу 72% нь ханшийн түвшин бизнес эрхлэхэд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа гэж хариулсан нь импортын бараанд түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчдэд ханшийн сулралт нь түүхий эдийн зардлыг өсгөж үйлдвэрлэлд дарамт учруулж байгааг харуулж байна. Улмаар эдийн засгийн эрч саарч, иргэдийн худалдан авалт муудсан өнөөгийн нөхцөлд түүхий эдийн үнэ ийнхүү өсөх нь борлуулалтанд нь сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм (*Шигтгээ 3*).

Шигтгээ 4.2: Инфляци

Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляци 2012 оны эцэст 14.2%-д хүрч байсан бөгөөд энэхүү өсөлт нь махны үнийн огцом өсөлтөөс голлон шалтгаалж байсан. Монголбанк Засгийн газартай хамтран 2012 оны эцсээс “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлснээр нийлүүлэлтийн гаралтай инфляци 2012 оноос 2013 оны хагас хүртэл буурч байсан. Гэвч 2012 оны дунд үеэс төгрөгийн ханшийн сулралтаас үүдэн импортын барааны (бензинээс бусад) үнэ өсөх хандлагатай болсон нь нэг талаас импортын барааны инфляцийг шууд замаар өсгөсөн ба нөгөө талаас дотоодын барааны орцын зардлыг нэмэгдүүлэх замаар дотоодын инфляцийг давхар нэмэгдүүлсэн.

Монголбанк 2014 оны 7-р сараас мөнгөний бодлогын төлөвөө хатууруулах чиглэлд барьсан нь үр дүнд хүрч эрэлтийн гаралтай инфляцийн дарамт 2014 оны дунд үеэс буурч, улмаар инфляцийн түвшин 2015 оны 5-р сарын байдлаар 7.5%-д хүрээд байна.



Эх үүсвэр: ҮСХ, Судлаачийн тооцоолол

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

ГШХО-ын бууралт нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь маш муу нөлөөг үзүүлж байна гэж ААН-үүдийн 24% нь, муу нөлөө үзүүлж байна гэж 40% нь хариуллаа. Харин санал асуулганд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 36% нь ГШХО-ын бууралт нь бизнес эрхлэх үйл ажиллагаанд боломжийн эерэг нөлөөг үзүүлсэн гэж дүгнэжээ (*Зураг 4.8*)

Зураг 4.8 Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Уул уурхайн салбар дахь ГШХО-ын эерэг үр дүнд Монгол улс 2011-2013 онуудад дэлхий дээрх хамгийн өндөр өсөлттэй орнуудын нэгээр нэрлэгдэж байв. Гэвч дотоодыг чиглэх ГШХО-ын бууралт болон дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн уналтаас шалтгаалж манай орон 2012 оны дунд үеэс төлбөрийн тэнцлийн хүндрэлд орсон нь төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханшийг сулруулж, улмаар инфляцийн түвшин өсөхөд нөлөөлсөн.

Шигтгээ 4.3: Нэрлэсэн ханш

2011-ээс 2013 онуудад эдийн засаг эрчтэй өсч, нийт эрэлт нэмэгдсэн нь урсгал тэнцлийн алдагдлыг (ДНБ-ий 30%) өсгөсөн бөгөөд энэхүү өндөр алдагдлыг Оюу толгойн хөрөнгө оруулалтаар голчлон нөхөж байсан. Гэвч 2013 оноос ГШХО оруулалт татарч, экспортын гол барааны үнэ буурсан нь манай улсыг төлбөрийн тэнцлийн хүндрэлд хүргэсэн.

Эх үүсвэр: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн өндөр алдагдал нь 2012 оны сүүл үеэс төгрөгийн ханш огцом сулрах үндсэн шалтгаан болсон. Энэхүү төлбөрийн тэнцлийн хүндрэл өнөөдөр ч үргэлжилсэн хэвээр байна. 2013 оны эцэст төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 1659.34 төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.2%-иар суларсан бол 2014 оны эцэст ханш 1888.44 төгрөгт хүрч өмнөх оноос 13.8%-иар суларсан байна. 2015 оны 5-р сарын байдлаар төгрөгийн ханш 1907,3 төгрөгт хүрч, оны эхнээс 1%, өмнөх оны мөн үеэс 4.9%-иар тус тус сулраад байна.

Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд ГШХО оруулалт огцом татарч, экспортын гол барааны дэлхийн зах зээл дээрх үнэ буурч эхэлсэн нь манай улсыг төлбөрийн тэнцлийн хүндрэлд хүргэсэн. Улмаар энэхүү хүндрэл нь эдийн засагт төгрөгийн нэрлэсэн ханшийн сулралт, бодит эдийн засгийн өсөлтийн уналт хэлбэрээр илэрч байна. Төгрөгийн ханшийн сулралт болон инфляци нь иргэдийн худалдан авалтыг бууруулж улмаар ААН-ийн орлогод сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн түүхий эд материалаа импортоор авдаг ААН-үүдийн хувьд түүхий эдийн зардлыг нэмэгдүүлж ЖДҮ эрхлэгчдэд ихээхэн дарамт болж байна.

4.3 Нийгэм, улс төрийн байдал

Монгол улсын ДНБ-ийн өсөлт 2014 онд 7.8%, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,512[7] ам доллар болж өмнөх оноос 1.1%-иар буурсан бөгөөд ажилгүйдлийн түвшин 7.9%-тай гарсан байна. Олон улсын "Transparency international" байгууллагын 2014 онд явуулсан судалгаагаар Монгол улсын авлигын индекс[8] 3.9 нэгж гарсан нь өмнөх жилийн судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.1 нэгжээр өсчээ.

Нэгдсэн дүн

ЖДҮ-ийн бизнес эрхлэхэд нийгмийн орчны зүгээс саад болж буй хүчин зүйлсийг **маш муу** /-2/-оос **маш сайн** /+2/ гэсэн чанарын асуултаар асууж, нэгдсэн үнэлгээг тоон утга руу шилжүүлэн тооцлоо.

Нийгмийн орчны хүчин зүйлсийг ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдал гэсэн таван үзүүлэлтээр тооцож бүлгийн индексийг гаргав. Түүвэр судалгааны үр дүнгээр нийгмийн орчны бүлгийн индекс **(-0.99)** буюу муу гэж дүгнэгдсэн хэдий ч өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан байна.

Зураг 4.9 Нийгмийн орчин
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Энэ удаагийн санал асуулгын дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд нийгмийн орчны зүгээс ажилгүйдэл, ядуурал хамгийн их хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна (*Зураг 4.10*)

[7] Дэлхийн банкны атласын аргачлал

[8] Энэхүү индекс нь 0-10 хооронд тодорхойлогдох бөгөөд 0-өндөр авлигатай, 10-бараг авлигагүй.

Зураг 4.10 Нийгмийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

ЖДҮ эрхлэхэд ядуурлын түвшин нийгмийн зүгээс ажилгүйдлийн дараа орох гол бэрхшээл гэж дүгнэсэн байна.

Шигтгээ 4.4: Ажилгүйдлийн түвшин

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үе болох 2008-2009 оны хооронд ажилгүйдлийн түвшин дунджаар 10.3%-тай гарсан байна. Манай орны экспортын гол бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор эдийн засаг сэргэж, улмаар ажилгүйдлийн түвшин 2011 онд дунджаар 7.8%-тай гарахад нөлөөлжээ.



Эх үүсвэр: УСХороо

Ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай байгаа бөгөөд Үндэсний Статистикийн хорооны “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр 2014 онд эдийн засгийн идэвхтэй хүн 1206.6 мянга байгаагаас 1110.7 мянга буюу 92.1% нь ажиллагсад 7.9% нь ажилгүй иргэд байна.

Ядуурал болон ажилгүйдлийн түвшин бизнес эрхлэхэд голлох бэрхшээл болж, хэрэглэгчийн худалдан авалт буурахад нөлөөлж байна. Хэрэглэгчийн худалдан авалт муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтад сөргөөр нөлөөж орлогыг бууруулж байна.

Шигтгээ 4.5: Хүн амын амьжиргааны доод түвшин

ҮСХ нь Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, "Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай" статистикийн хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгийн дагуу 2015 онд мөрдөх "Хүн амын амьжиргааны доод түвшин"-г бүс нутгаар шинэчлэн тооцжээ. Үүнд: баруун бүс 164.2 мянган төгрөг, хангайн бүс 167.2 мянган төгрөг, төвийн бүс 164.3 мянган төгрөг, зүүн бүс 160.8 мянган төгрөг, Улаанбаатар хотод 185.4 мянган төгрөг байна.

мянган төгрөг

	2010	2011	2012	2013	2014	2015
Баруун бүс	97.0	104.3	115.6	132.0	146.6	164.2
Хангайн бүс	91.5	105.1	116.8	130.9	149.6	167.2
Төвийн бүс	91.7	106.6	117.5	132.4	149.7	164.3
Зүүн бүс	90.9	103.5	113.0	130.5	144.5	160.8
Улаанбаатар	101.6	118.1	126.5	149.9	169.0	185.4
Дундаж өсөлт		**14%**	**10%**	**15%**	**12%**	**11%**

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хүн амын амьжиргааны доод түвшин 2013 онд 15%, 2014 онд 12%-иар тус тус өссөн бол 2015 онд өсөлтийн хурд бага зэрэг саарч 11%-тай байна. Эдийн засгийн таагүй байдал үргэлжилж байгаа нь хүн амын амьжиргааны доод түвшний өсөлт саарах, улмаар хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудахад нөлөөлж байна.

Улс төрийн байдал, хээл хахууль ЖДҮ эрхлэхэд ихээхэн хүндрэл болдог гэж үзжээ. Үүнд 2012 онд УИХ болон орон нутгийн сонгуулийн дараа нөхөн сонгууль удаа дараа явагдсан, сонгуулийн үр дүнтэй холбоотойгоор бодлогын болон бүтцийн өөрчлөлт бий болдог нь ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд хүндээр тусдаг байна. Олон улсын "Transparency international" байгууллагын 2014 онд явуулсан судалгаагаар Монгол улсын авлигын индекс өмнөх оноос бага зэрэг сайжирч 3.9 нэгж гарсан ч авлига, хээл хахууль ихтэй гэсэн түвшинд хэвээр байна.

Шигтгээ 4.6: Авлигын индекс

Олон улсын “Transparency international” байгууллагаас тооцдог авлигын индекс нь 0-10 хооронд орших бөгөөд индексийн утга 0.0-той ойролцоо байвал авлига ихтэй гэж ойлгоно.



Эх үүсвэр: Transparency international

Эсрэг тохиолдолд тухайн улсын авлигын индексийн тоон утга 10-тай ойр байснаар авлига, хээл хахууль доогуур түвшинд байгааг илэрхийлнэ.

“Transparency international” байгууллагын судалгаагар 2007 оноос 2011 оныг хүртэл авлигын индекс бага зэргийн бууралттай гарчээ. Харин 2012 онд авлигын индекс өмнөх оноос 0.9 нэгжээр нэмэгдсэн байна.

Хулгай, дээрэм, залилан болон бие мах бодод гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэг нийгэмд түгээмэл байсаар байгаа нь ЖДҮ эрхлэхэд саад учруулж буй бас нэгэн бэрхшээл болж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2015 оны 5 дугаар сарын байдлаар 12.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 11.2 %-иар өссөн байна.

Аймаг, нийслэлээр

Нийгмийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Төв аймгийн ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинд хамгийн муу үнэлгээг өгчээ. Сүхбаатар, Булган аймгуудын ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад нийгмийн орчинг муу гэж үзжээ.

Зураг 4.11 Нийгмийн орчин, аймгуудаар
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин Архангай, Дорнод, Хөвсгөл болон Говьсүмбэр аймгуудын ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулж байна гэж үзжээ.

Ядуурал, ажилгүйдэл нь Ховд, Сүхбаатар, Булган, Төв болон Говь-Алтай аймгуудын бизнес эрхлэгчдэд илүү хүндрэл учруулж байгаа бол Говьсүмбэр, Архангай, Дорнод аймгуудад харьцангуй бага хүндрэлтэй байна (*Хүснэгт 4.1*).

Нийгмийн орчинд хамгийн муу үнэлгээг Ховд, Төв, Сүхбаатар, Булган аймгуудын судалгааны оролцсон ЖДҮ эрхлэгчид өгсөн бөгөөд ядуурал, ажилгүйдлээс гадна хээл хахууль болон улс төрийн байдал бизнесийн үйл ажиллагаанд нь нэлээд хүндрэл учруулдаг байна. Мөн Дархан-Уул, Говь-Алтай, Төв, Сүхбаатар, Орхон болон Ховд аймгуудын ЖДҮ эрхлэгчид хээл хахууль болон улс төрийн байдалд муу гэсэн үнэлгээг өгчээ.

Хүснэгт 4.1 Нийгмийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн)

	Ядуурал	Ажилгүйдэл	Гэмт хэрэг	Хээл хахууль	Улс төрийн байдал
Улсын дүн	**-1.05**	**-1.10**	**-0.92**	**-0.94**	**-0.94**
Архангай	-0.80	-0.73	-0.50	-0.73	-0.76
Баян-Өлгий	-0.88	-1.06	-0.40	-0.71	-0.76
Баянхонгор	-1.14	-0.98	-0.69	-0.90	-0.91
Булган	-1.30	-1.24	-0.94	-1.18	-1.15
Дархан-Уул	-1.17	-1.11	-0.88	-1.02	-1.29
Дорнод	-0.81	-0.74	-0.62	-0.62	-0.68
Дорноговь	-1.09	-1.19	-0.91	-0.90	-0.86
Дундговь	-0.92	-0.95	-0.59	-0.84	-0.74
Говь-Алтай	-1.43	-1.40	-0.64	-1.06	-1.25
Говьсүмбэр	-0.59	-0.62	-0.43	-0.53	-0.69
Хэнтий	-1.06	-1.04	-0.65	-0.98	-0.90
Ховд	-1.37	-1.27	-1.16	-1.32	-1.29
Хөвсгөл	-1.03	-1.06	-0.24	-0.50	-0.54
Орхон	-1.07	-1.04	-0.85	-1.26	-1.23
Сэлэнгэ	-0.98	-0.94	-0.79	-0.88	-1.00
Сүхбаатар	-1.30	-1.20	-0.78	-1.23	-1.40
Төв	-1.21	-1.37	-1.19	-1.25	-1.25
Улаанбаатар	-1.03	-1.13	-1.08	-0.93	-0.94
Өмнөговь	-1.11	-1.07	-0.70	-0.76	-0.84
Увс	-1.17	-1.10	-0.88	-1.16	-1.14
Өвөрхангай	-0.92	-1.00	-0.77	-0.94	-1.04
Завхан	-0.96	-1.11	-0.91	-1.02	-1.06

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дүгнэлт

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинд ерөнхийдөө муу гэсэн үнэлгээг өгсөн хэдий ч өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан байна. Санал асуулгын үр дүнгээс харахад ЖДҮ-ийн хөгжилд нийгмийн зүгээс учруулах хамгийн гол бэрхшээл нь ажилгүйдэл, ядуурал болж байна. Харин хээл хахууль, улс төрийн байдал бизнес эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг гэж үзжээ.

Ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нэг талаас ядуурлын түвшинг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн худалдан авалтыг бууруулж байна. Үүнээс шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүйд хүрч, урт хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлүүдтэй тулгарах магадлалтай. Нөгөө талаас ядуурал, ажилгүйдэл нийгэмд өндөр байгаагаас ЖДҮ эрхлэгчдийн тодорхой хэсэг нь санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй байгааг харуулж байна.

4.4 Хууль эрх зүйн орчин

ЖДҮ-ийн эрх зүйн орчинг сайжруулан, ЖДҮ-ийг хөгжүүлснээр өрсөлдөх чадвар бүхий ЖДҮ-үүд бий болж, ажлын байр нэмэгдэн, ажилгүйдэл, ядуурал буурч, дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх чухал үр нөлөөтэй. Иймээс улс орнууд ЖДҮ эрхлэгчдэд хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч, бодлогын арга хэмжээг авсаар байна. Манай орны хувьд:

Хүснэгт 4.2 ЖДҮ-тэй холбоотой хууль, тогтоомж

Огноо	Хуулийн нэр	Ач холбогдол
2006 он	Санхүүгийн түрээсийн тухай хууль	Барьцаа хөрөнгийн боломж таарууу бизнес эрхлэгчдэд худалдан авч байгаа тоног төхөөрөмжөө барьцаалан зээл авч үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдсэн.
2007 он	Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль	Жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжилд ЖДҮ-ийн үзүүлэх хувь нэмэр, ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.
2007 он	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	ЖДҮ шинээр бий болох, өргөжин хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх.
2009 он	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль	ЖДҮ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох ач холбогдолтой.
2009 он	Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль	Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх. 2014 оны 6 сард Засгийн газрын тогтоолоор 594 төрлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтыг гаргасан байна.
2011 он	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Малчин, хувираа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг арга зүй, зөвлөгөө, сургалт, санхүүгийн талаар дэмжих талаар тусгагдсан байна.
2012 он	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилготой. Улмаар банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах болсон.
2013 он	“Ажилтай орлоготой, Монгол хүн” үндэсний хөтөлбөр	Жижиг, дунд үйлдвэр, хувираа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох ач холбогдолтой.
2014 он	“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” 2014-2016	Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд оршино.
2015 он	Багцын батлан даалтын гэрээ	Зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгж барьцаа хөрөнгөгүйн улмаас банкны шалгуурт бүдэрч санхүүгийн дэмжлэг авах боломжгүй болдог юм. Энэ байдлыг өөрчилж, иргэнд ээлтэйгээр зохицуулах боломжийг олгох давуу талтай.

Эх үүсвэр: www.legalinfo.mn

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны хүрээнд ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй тодорхой ажлууд хийгдэж байгаа ч үр дүн, хэрэгжилт нь хангалттай бус гэж санал асуулгад оролцогсод үзсэн байна.

Нэгдсэн дүн

Энэ удаагийн үүвэр судалгааны үр дүнгээр хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны бүлгийн индекс **(-0.60)** буюу муу гэж дүгнэгдсэн нь судалгаа авч эхэлснээс хойш хамгийн муу түвшиндээ хүрчээ.

Зураг 4.12 Хууль эрх зүйн орчин (*-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчныг дотор нь задлан авч үзвэл хуулийн хэрэгжилт сул, төрийн байгууллагын үйлчилгээ хүнд сурталтай, газар эзэмших боломж муу байгаа нь ЖДҮ эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна гэж үзжээ.

Зураг 4.13 Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид хуулийн хэрэгжилтэд хамгийн муу үнэлгээг өгсөн бөгөөд үүнд “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”, “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль” зэрэг жижиг дунд үйлдвэрлэлтэй холбоотой болон холбогдох хууль, журмын хэрэгжилт сул, хуулиа дагаж мөрддөггүйтэй холбоотой байх талтай.

ЖДҮ эрхлэгчид хээл хахууль бизнесийн үйл ажиллагаанд нь их хүндрэл учруулдаг, хүнд суртал ихтэй байдаг зэргээс шалтгаалж төрийн байгууллагын үйлчилгээнд доогуур үнэлгээг өгөхөд хүргэжээ.

Шигтгээ 4.7: Хэрэгцээний зориулалтаар иргэнд газар өмчлүүлэх тухай

НИТХ-ын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 10/39-р тогтоолоор гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээг тогтоосон. Тогтоолын дагуу Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх, Багануур, Багахангай дүүрэгт нийт 15,309 га газрыг гэр бүлийн зориулалтаар иргэдэд өмчлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төлөвлөлтөд хамрагдсан газрыг хамгаалалтанд авах, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол хийлгэх, 2014-2016 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах замаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлэх ажлыг нийслэлийн Засаг дарга зохион байгуулж байна.

Хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ

Дүүрэг	Хэмжээ	Төлөвлөлт хийсэн газрын байршлын тоо
Баянзүрх	1,232.0 га	15
Хан-Уул	2,590.0 га	7
Сонгино хайрхан	8,018.0 га	21
Сүхбаатар	87.0 га	2
Налайх	166.0 га	1
Багануур	1,852.0 га	3
Багахангай	1,364.0 га	3
Нийт	**15,309.0 га**	**52**

Газар эзэмших боломжинд өгсөн үнэлгээ өмнөх судалгаанаас бага зэрэг буурсан дүнтэй байна. ААН, иргэнд хэрэгцээний болон үйл ажиллагааны зориулалтаар газар өмчлүүлж байгаа хэдий ч аж ахуйн зориулалтаар байршил сайтай газар хувьчилж авахад хүндрэлтэй хэвээр байгаа гэжээ.

Шигтгээ 4.8: Засаглалын индекс

Дэлхийн банкны хувьд засаглалын чанарыг тодорхойлж, хэмжих тал дээр маш олон судалгааны ажлыг хийсэн ба үүний үр үндсэн 6 үзүүлэлт дээр тулгуурлан 215 улс орны засаглалын индексийг тооцдог байна.

Засаглалын индекс нь **-2.5** аас **+2.5** хооронд орших бөгөөд индексийн утга +2.5 тай ойролцоо байвал засаглалын чанар сайн гэж ойлгоно. Эсрэг тохиолдолд тухайн улсын засаглалын индексийн тоон утга -2.5 тай ойр байснаар засаглалын чанар доогуур түвшинд байгааг харуулна.

Монгол улсын засаглалын индекс 2008-2013

	2008	**2009**	**2010**	**2011**	**2012**	**2013**
Дуу хоолой ба хариуцлагатай байдал[9]	0.24	0.09	0.04	0.00	0.03	0.07
Улс төрийн тогтвортой байдал	0.57	0.60	0.59	0.60	0.47	0.50
ЗГ-ын үр ашигт байдал[10]	-0.52	-0.66	-0.57	-0.58	-0.63	-0.54
Зохицуулалтын байдал[11]	-0.33	-0.28	-0.23	-0.20	-0.17	-0.29
Хуулийн хэрэгжилт[12]	-0.38	-0.28	-0.39	-0.30	-0.38	-0.37
Авлигын хяналт[13]	-0.67	-0.76	-0.73	-0.68	-0.52	-0.46
Эх үүсвэр: The Worldwide Governance Indicators (2008-2013)						

Аймаг, нийслэлээр

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд аймаг хамгийн муу үнэлгээтэй гарсан бөгөөд түүний дараагаар Говь-Алтай, Булган, Орхон аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин муу бүрдсэн гэж үзжээ *(Зураг 4.14)*.

[9] Хүний үг хэлэх эрх чөлөө
[10] Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар
[11] Засгийн газрын эдийн засгийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх чадвар
[12] Хуулийн хэрэгжилт, биелэлт
[13] Төрийн эрх мэдлийг хувийн ашиг, сонирхолд ашиглах явдал

Зураг 4.14 Хууль эрх зүйн орчин, аймгуудаар
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин Хэнтий, Говьсүмбэр, Сэлэнгэ, Баян-Өлгий аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад хууль эрх зүйн тогтолцоо, төрийн үйлчилгээ нь боломжийн байгаа гэсэн үнэлгээг өгсөн байна.

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдээр авч үзвэл хуулийн хэрэгжилт, төрийн байгууллагын үйлчилгээ нь Булган, Ховд, Говь-Алтай аймгуудын бизнес эрхлэгчдэд илүү хүндрэл учруулж байгаа бол Говьсүмбэр, Хэнтий, Сэлэнгэ аймгуудад харьцангуй бага хүндрэлтэй байна.

Ховд, Говь-Алтай, Орхон аймагт үйлдвэрлэл эрхлэхэд газар эзэмших боломж муу байна гэж үзсэн байна. Дорнод, Сэлэнгэ, Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад гадаад худалдаа хийх боломж харьцангуй боломжийн гэж дүгнэжээ.

Хүснэгт 4.3 Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)

	Хуулийн хэрэгжилт	Татварын тогтолцоо	Гадаад худалдаа хийх нөхцөл	Төрийн байгууллагын үйлчилгээ	Хяналт шалгалтын тогтолцоо	Газар эзэмших боломж
Улсын дүн	**-0.72**	**-0.55**	**-0.61**	**-0.65**	**-0.46**	**-0.61**
Архангай	-0.49	-0.25	-0.54	-0.64	-0.28	-0.63
Баян-Өлгий	-0.63	-0.26	-0.28	-0.60	-0.22	-0.24
Баянхонгор	-0.65	-0.69	-0.69	-0.57	-0.30	-0.49
Булган	-1.02	-0.86	-0.84	-0.77	-0.68	-0.57
Дархан-Уул	-0.73	-0.59	-0.38	-0.71	-0.54	-0.27
Дорнод	-0.58	-0.58	-0.42	-0.49	-0.26	-0.47
Дорноговь	-0.85	-0.67	-0.69	-0.76	-0.63	-0.43
Дундговь	-0.62	-0.41	-0.47	-0.50	-0.32	-0.49
Говь-Алтай	-0.91	-0.80	-0.90	-0.85	-0.61	-0.83
Говьсүмбэр	-0.46	-0.19	-0.52	-0.46	-0.23	-0.52
Хэнтий	-0.58	-0.44	-0.32	-0.33	-0.38	-0.42
Ховд	-1.00	-0.92	-0.69	-1.13	-0.91	-1.09
Хөвсгөл	-0.61	-0.64	-0.41	-0.54	-0.58	-0.44
Орхон	-0.85	-0.71	-0.77	-0.89	-0.70	-0.83
Сэлэнгэ	-0.63	-0.45	-0.35	-0.38	-0.33	-0.20
Сүхбаатар	-0.73	-0.78	-0.65	-0.75	-0.65	-0.59
Төв	-0.85	-0.52	-0.60	-0.69	-0.52	-0.73
Улаанбаатар	-0.71	-0.52	-0.62	-0.64	-0.44	-0.70
Өмнөговь	-0.61	-0.78	-0.76	-0.52	-0.24	-0.30
Увс	-0.84	-0.68	-0.65	-0.63	-0.55	-0.43
Өвөрхангай	-0.73	-0.27	-0.60	-0.59	-0.47	-0.40
Завхан	-0.89	-0.51	-0.81	-0.81	-0.73	-0.66

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Улаанбаатар хотод ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчид хуулийн хэрэгжилт, газар эзэмших боломж, төрийн байгууллагын үйлчилгээнд хамгийн тааруу үнэлгээг өгсөн бол хяналт шалгалтын тогтолцоог боломжийн гэж үзсэн байна.

Дүгнэлт

Энэ удаагийн судалгаагаар хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчинд өгсөн үнэлгээ судалгаа авч эхэлснээс хойш хамгийн муу түвшиндээ хүрсэн байна. ЖДҮ эрхлэгчид хуулийн хэрэгжилтэд хамгийн муу үнэлгээг өгсөн бөгөөд үүнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг төдийлөн хангалттай дагаж мөрдөхгүй байгаа, төрийн байгууллагын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэл ихтэй зэрэг нь голлон нөлөөлжээ.

Газар эзэмших боломжинд өгсөн үнэлгээ өмнөх судалгаанаас бага зэрэг буурсан дүнтэй байна. ААН, иргэдэд хэрэгцээний болон үйл ажиллагааны зориулалтаар газар өмчлүүлж байгаа хэдий ч газар олгох үйл явц, зохион байгуулалт тааруу мөн үйл ажиллагаа явуулахад тохиромжтой байршилд аж ахуйн зориулалтаар газар хувьчилж авах боломж бага байдаг нь хүндрэлтэй гэж үзжээ.

4.5 Зах зээлийн орчин

Макро эдийн засгийн орчин, зах зээлийн хэмжээ, технологийн дэвшил зэрэг 12 үзүүлэлтүүдэд тулгуурлан тухайн улсын өрсөлдөх чадварын зэрэглэлийг дэлхийн эдийн засгийн форумаас тодорхойлдог байна. 2014-2015 оны судалгааны дүнгээр (*2012-2013 оны судалгааны дүнтэй харьцуулахад*) зах зээлийн хэмжээ бага зэрэг томорсон хэдий ч технологийн дэвшил, макро эдийн засгийн орчны индекс буурсан байна.

Шигтгээ 4.9: Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

- Манай улсын эдийн засгийн өсөлт 2015 оны I улирлын байдлаар 4.4%-тай гарсан нь 2014 оны I улиралтай харьцуулахад 3.0 нэгж хувиар буурсан дүнтэй байна.
- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2014 оны 5 дугаар сард 26%-иар (жилийн өөрчлөлт) суларсан бол 2015 оны 5 дугаар сарын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 орчим хувиар суларсан байна.
- Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2014 оны 5 дугаар сард 30 орчим хувьтай байсан бол 2015 оны 5 дугаар сард хасах 4 хувь болтлоо буурчээ.

Эх үүсвэр: Монголбанк

Өрхийн орлого, зарлага: жилийн өсөлт

Бодит орлогын өсөлтийг авч үзвэл 2013 онд 20 орчим хувийн өсөлттэй 2014 онд 9%-ийн өсөлттэй гарсан бол 2015 оны эхний улирлын байдлаар 7%-йн өсөлттэй байна.



Эх үүсвэр: ҮСХороо

Орлогын өсөлтийн хурд саарсан, нөгөө талаас зарлагын өсөлт орлогын өсөлтөөс давсан нь өрхийн амьжиргааны түвшин төдийлөн сайжрахгүй байгааг харуулж байна.

Технологийн дэвшил болон макро эдийн засгийн орчны индекс бууралттай гарахад дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт саарсан, эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилж төгрөгийн ханш сулрах дарамт хэвээр байгаа, манай улсын зээлжих зэрэглэл муудсан зэрэг хүчин зүйлстэй холбоотой.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зах зээлийн орчны бүлгийн индексийг **(-0.40)** буюу харьцангуй боломжийн гэж дүгнэсэн хэдий ч өмнөх судалгаануудын дүнгээс эрс буурчээ. Үүнд хэрэглэгчдийн худалдан авах чадвар огцом муудсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.15 Зах зээлийн орчин
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр:Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Энэ удаагийн судалгаагаар зах зээлийн орчныг илэрхийлэх хүчин зүйлсээс **хэрэглэгчдийн худалдан авах чадвар (-0.80)** хамгийн муу үнэлгээтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ.

Зураг 4.16 Зах зээлийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилж, төгрөгийн ханш сулрах дарамт хэвээр байгаа, нөгөө талаас ипотекийн зээлтэй иргэдийн хэрэглээ хумигдсан зэргээс шалтгаалан хэрэглэгчдийн худалдан авалт буурсан байх талтай. Түүнчлэн зах зээлийн багтаамж муу, зах зээлийн өрсөлдөөн боломжийн байна гэж үзсэн нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Шигтгээ 4.10: Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (2014)

Монгол улс уг судалгаанд 2005 оноос эхлэн хамрагдсан бөгөөд 2014-2015 оны тайлан судалгаагаар 3.8 оноогоор 144 орноос 98-р байрт орсон нь өнгөрсөн онд 148 орноос 107-р байрт орсон үзүүлэлтээсээ сайжирсан байна. Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсанаас хойших хугацаанд Монгол Улсын зэрэглэл 2010-2012 онуудад сайжирч эхний 100-д багтаж байсан бөгөөд 2014-2015 оны тайлангаар манай улсын зэрэглэл өмнөх судалгааны дүнгээс эрс сайжирсан байна.

Монгол улсын өрсөлдөх чадварын зэрэглэл



Эх үүсвэр: The Global Competitiveness Report (2006-2014)

12 тулгуур үзүүлэлтээс ихэнх нь буюу 8 үзүүлэлтийн хувьд Монгол улсын байр урагшилсан байна. Манай улсын зэрэглэл ийнхүү өмнөх судалгааны дүнгээс эрс сайжирч нийт 144 орноос эхний 100-д багтахад дэд бүтэц, институци болон эрүүл мэнд, суурь боловсролын хангамж сайжирсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Монгол улсын өрсөлдөх чадварын зэрэглэл 2012-2014

Эх үүсвэр: The Global Competitiveness Report (2012,2014)

Аймаг, нийслэлээр

Зах зээлийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Говь-Алтай, Булган аймагт зах зээлийн орчин хамгийн муу үнэлгээтэй гарлаа. Ховд, Төв аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад бизнес эрхлэх зах зээлийн орчин муу бүрдсэн гэж үзжээ *(Зураг 5.14)*.

Харин Дорнод, Баян-Өлгий болон Архангай аймгийн бизнес эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зах зээлийн орчин боломжийн байгаа гэсэн үнэлгээг өгчээ.

Зураг 4.17 Зах зээлийн орчин, аймгуудаар
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр:Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Зах зээлийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Булган, Говь-Алтай, Ховд болон Хөвсгөл аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад хэрэглэгчдийн худалдан авах чадварт муу гэсэн үнэлгээг өгчээ *(Хүснэгт 4.4)*.

Хүснэгт 4.4 Зах зээлийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)

	Хэрэглэгчийн худалдан авах чадвар	Зах зээлийн багтаамж	Зах зээлийн өрсөлдөөн	Мэдээллийн хүртээмж	Технологийн дэвшил
Улсын дүн	**-0.80**	**-0.55**	**-0.26**	**-0.25**	**-0.14**
Архангай	-0.39	-0.18	0.12	0.00	0.02
Баян-Өлгий	-0.80	-0.40	0.06	0.44	0.27
Баянхонгор	-0.90	-0.43	-0.17	-0.03	0.08
Булган	-1.21	-0.98	-0.60	-0.62	-0.54
Дархан-Уул	-0.86	-0.49	0.04	-0.05	0.16
Дорнод	-0.45	-0.21	0.11	-0.09	0.09
Дорноговь	-0.70	-0.43	-0.21	-0.43	-0.26
Дундговь	-0.92	-0.45	-0.28	-0.32	-0.17
Говь-Алтай	-1.30	-1.02	-0.36	-0.69	-0.72
Говьсүмбэр	-0.77	-0.75	-0.44	-0.41	0.04
Хэнтий	-0.85	-0.55	0.00	-0.02	0.02
Ховд	-1.06	-0.76	-0.45	-0.49	-0.44
Хөвсгөл	-1.02	-0.14	0.34	-0.10	0.16
Орхон	-0.84	-0.55	-0.33	-0.18	0.00
Сэлэнгэ	-0.77	-0.42	-0.04	-0.04	0.00
Сүхбаатар	-0.83	-0.70	-0.10	-0.18	0.00
Төв	-0.94	-0.71	-0.58	-0.25	-0.15
Улаанбаатар	-0.75	-0.58	-0.35	-0.31	-0.21
Өмнөговь	-0.65	-0.54	-0.24	-0.07	-0.02
Увс	-0.94	-0.63	-0.28	-0.20	-0.06
Өвөрхангай	-0.70	-0.35	0.00	0.02	0.04
Завхан	-0.86	-0.51	-0.26	-0.31	-0.17

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд зах зээлийн орчинд муу гэсэн үнэлгээг өгчээ. Үүнд эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилж, төгрөгийн ханш сулрах дарамт хэвээр байгаа, нөгөө талаас ипотекийн зээлтэй иргэдийн хэрэглээ хумигдсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Орлогын өсөлтийн хурд саарсан, нөгөө талаас зарлагын өсөлт орлогын өсөлтөөс давж өрхийн амьжиргааны түвшин төдийлөн сайжрахгүй байгаа нь хэрэглэгчийн худалдан авах чадвар болон зах зээлийн багтаамжид сөргөөр нөлөөлж байна.

Зах зээлийн орчныг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Говь-Алтай, Булган, Ховд, Төв аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бизнес эрхлэх зах зээлийн орчинд муу гэсэн үнэлгээг өглөө.

Зах зээлийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Булган, Говь-Алтай, Ховд болон Хөвсгөл түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ.

4.6 Дэд бүтцийн хөгжил

Дэд бүтцийн хөгжил нь аливаа улсын бизнес эрхлэхэд нөлөөлөх суурь хүчин зүйлсийн нэг болдог. Тиймээс дэлхийн өрсөлдөх чадварын судалгаанд дэд бүтцийн хөгжлийг улс орнуудын өрсөлдөх чадвар, бизнес эрхлэхэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох 12 хүчин зүйлсийн нэгээр авч үздэг.

2014 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас эрхлэн гаргасан “Өрсөлдөх чадварын судалгаа”-гаар Монгол улс дэд бүтцийн хөгжлөөрөө авбал зохих 7 онооноос 2.9 оноо авч, 144 орноос 112-рт жагсаж байгаагаас харахад дэд бүтцийн хөгжлөөр бусад орнуудтай харьцуулахад нэлээд доогуур түвшинд байна.

Дэд бүтэц, ялангуяа зам тээврийн хөгжил хүртээмж сайтай байх нь аливаа бизнесийн үйл ажиллагаанд чухал хүчин зүйл юм. Монгол улс нийт 12,722 км авто замтай бөгөөд үүнээс 3000 орчим нь хатуу хучилттай зам байна. 2014 онд Өмнөговь, Баянхонгор, Хөвсгөл, Сүхбаатар, Дундговь, Дорноговь аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар холбож дуусгасан бөгөөд 2016 он гэхэд бүх аймгуудыг холбох төлөвлөгөөтэй байна.

Энэ түүвэр судалгаагаар ЖДҮ-ийн хөгжилд дэд бүтцийн байдал хэрхэн нөлөөлж байгааг зам, дулаан шугам сүлжээ, тээвэрлэлт, усан хангамж, цахилгаан түгээлт болон мэдээлэл холбоо зэрэг хүчин зүйлсээр тодорхойлон авч үзлээ.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад орчны бүлгийн индексүүдтэй харьцуулахад хамгийн бага хүндрэлтэй (**-0.13**) буюу ерөнхийдөө боломжийн гэсэн үнэлгээг өглөө. Харин өмнөх онтой харьцуулахад дэд бүтцийн байдал бага зэрэг муудсан үнэлгээтэй гарсан байна.

Зураг 4.18 Дэд бүтцийн орчин *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дэд бүтцийн орчны бүлгийн индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл замын хөгжил болон дулаан шугам сүлжээний байдал бусад үзүүлэлттэй

харьцуулахад бага зэрэг муу гэж дүгнэгдлээ. Харин цахилгаан түгээлт болон мэдээлэл холбооны салбарыг боломжийн сайн гэж дүгнэсэн байна (*Зураг 4.19*).

Зураг 4.19 Дэд бүтцийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр:Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дэд бүтцийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Завхан, Говь-Алтай, Ховд зэрэг төвөөс алслагдсан баруун бүсийн аймгуудын ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдал хамгийн хүндрэлтэй гэж үзэж байна.

Зураг 4.20 Дэд бүтцийн орчин, аймгуудаар
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин Баянхонгор, Говьсүмбэр, Сэлэнгэ зэрэг аймгуудын ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг боломжийн сайн гэж үзсэн нь эдгээр аймгуудын дийлэнх нь

хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдсон аймгууд юм /*Зураг 4.20*/.

Дэд бүтцийн хөгжлийг үзүүлэлт бүрээр харвал **зам тээврийн хөгжлийг** Завхан, Баян-Өлгий, Дархан-Уул, Говь-Алтай болон Ховд аймгуудын бизнес эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад хамгийн муу үнэлгээ өгсөн байна. Харин Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь болон Хөвсгөл зэрэг аймгуудад зам тээврийн хөгжлөө боломжийн сайн гэж үнэлжээ */Хүснэгт 4.5/*.

Дулаан хангамжийн хувьд Сэлэнгэ, Баянхонгор, Дорнод аймгууд эерэг үнэлгээ өгч, бусад аймгууд ерөнхийдөө сайн биш үнэлгээг өгч байна. Үүнээс Говь-Алтай, Булган, Завхан аймгуудын ЖДҮ эрхлэгчдэд **дулаан хангамжийн** асуудал бусад аймгуудтай харьцуулахад хамгийн хүндрэлтэй байна.

Усан хангамжийн асуудал Булган, Ховд, Говь-Алтай аймгуудад хамгийн хүндрэлтэй байгаа бол Сэлэнгэ, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Архангай аймгуудад бизнес эрхлэгчид боломжийн сайн гэж үзэж байна. Ховд, Говь-Алтай, Булган болон Өмнөговь аймгуудад үйл ажиллагаа эрхлэгчид **цахилгаан хангамжийн** асуудлыг бусад аймагтай харьцуулахад муу гэж дүгнэсэн бол бусад аймгууд харьцангуй боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.

Мэдээлэл холбооны хувьд аймгууд ерөнхийдөө боломжийн сайн гэж дүгнэж байна. Баян-Өлгий, Баянхонгор, Увс аймгууд бусад аймгуудтай харьцуулахад хамгийн сайн үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 4.5 Дэд бүтцийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)

	Зам	Дулааны шугам сүлжээ	Тээвэрлэлт	Усан хангамж	Цахилгаан түгээлт	Мэдээлэл холбоо
Улсын дүн	**-0.37**	**-0.29**	**-0.19**	**-0.14**	**0.02**	**0.18**
Архангай	0.02	-0.22	0.12	0.00	0.06	0.28
Баян-Өлгий	-0.76	-0.36	-0.20	0.12	0.44	0.61
Баянхонгор	0.06	0.00	0.21	0.09	0.50	0.51
Булган	-0.35	-0.79	-0.26	-0.62	-0.28	-0.06
Дархан-Уул	-0.70	-0.11	-0.26	-0.04	0.02	0.33
Дорнод	-0.49	0.00	-0.15	-0.02	0.23	0.13
Дорноговь	0.12	-0.05	0.17	-0.15	-0.05	0.29
Дундговь	0.37	-0.55	0.39	-0.11	0.08	0.28
Говь-Алтай	-0.76	-0.96	-0.75	-0.46	-0.35	0.06
Говьсүмбэр	0.29	-0.07	0.35	0.00	0.24	0.33
Хэнтий	-0.30	-0.39	-0.02	-0.16	-0.08	0.15
Ховд	-0.63	-0.56	-0.40	-0.67	-0.45	-0.04
Хөвсгөл	0.24	-0.06	0.35	-0.04	0.14	0.22
Орхон	-0.48	-0.13	-0.20	-0.11	0.00	0.11
Сэлэнгэ	-0.12	0.15	0.04	0.22	0.22	0.40
Сүхбаатар	0.30	-0.38	0.08	-0.38	0.25	0.43
Төв	-0.37	-0.25	-0.31	-0.25	-0.04	-0.13
Улаанбаатар	-0.46	-0.29	-0.28	-0.12	0.02	0.14
Өмнөговь	-0.20	-0.17	-0.10	-0.19	-0.21	0.17
Увс	-0.06	-0.04	-0.06	-0.04	0.25	0.46
Өвөрхангай	-0.34	-0.24	-0.06	-0.06	0.02	0.21
Завхан	-1.33	-0.77	-0.78	-0.43	-0.17	0.07

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид зам тээвэр, дулаан хангамж бага зэрэг хүндрэлтэй, бусад үзүүлэлтийн хувьд харьцангуй боломжийн гэсэн үнэлгээг өглөө.

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн бүлгийн индексүүдтэй харьцуулахад хамгийн боломжийн **(-0.13)** гэсэн үнэлгээг өгсөн боловч өмнөх судалгаатай харьцуулахад бага зэрэг муудсан үр дүнтэй байна.

Дэд бүтцийн хөгжлийг тодорхойлох үзүүлэлт тус бүрээр харвал зам тээвэр, дулаан усан хангамж бага зэрэг муу үнэлгээтэй гарч байна. Харин цахилгаан түгээлт болон мэдээлэл холбооны хөгжил боломжийн гэсэн үнэлгээтэй байна.

Аймаг нийслэлээр авч үзвэл хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй төвөөс алслагдсан, баруун бүсийн аймгуудад дэд бүтцийн хөгжил харьцангуй муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байна.

Мөн Улаабаатар хот болон төвийн бүсийн зарим аймгуудад ЖДҮ эрхлэгчид зам, тээврийн асуудал бага зэрэг хүндрэлтэй бөгөөд шинээр зам барих болон засварын ажлын чанар хангалттай биш, хугацаа удаан байдаг гэж үзжээ.

4.7 Дотоод үйл ажиллагааны нөхцөл

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад дотоод орчны хувьд нөлөөлөх хүчин зүйлсийг ажиллах хүчний нийлүүлэлт, ажилчдын ур чадвар, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, барилга байгууламжийн хүрэлцээ, түүхийн эдийн олдоц, тоног төхөөрөмжийн чанар болон өрсөлдөх чадвар зэрэг үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн авч судаллаа.

Нэгдсэн дүн

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дотоод үйл ажиллагааны нөхцөлийг бага зэрэг хүндрэлтэй **(-0.25)** гэсэн үнэлгээг өглөө. ЖДҮ эрхлэгчдэд дотоод хүчин зүйлсээс ажиллах хүчний нийлүүлэлт, тэдний ур чадвар илүү хүндрэл учруулдаг гэж үзэж байна. Үүний дараа шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, барилга байгууламжийн хүрэлцээ, түүхийн эдийн олдоц бага зэрэг хүндрэл учруулж байна. Өрсөлдөх чадвар, тоног төхөөрөмжийн чанарыг хамгийн бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн байна (*Зураг 4.21*).

Зураг 4.21 Дотоод орчин, үзүүлэлтээр *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дотоод орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Булган, Сүхбаатар, Говь-Алтай аймгуудын үнэлгээ бусад аймгуудтай харьцуулахад хамгийн муу байна.

Зураг 4.22 Дотоод орчин, аймгуудаар *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Харин Өмнөговь аймагт ЖДҮ эрхлэгчдийн хувьд дотоод үйл ажиллагааны нөхцөлд эерэг үнэлгээ өгсөн байна. Дорноговь, Архангай болон Дорнод зэрэг аймгуудад дотоод үйл ажиллагааны нөхцөлийг харьцангуй боломжийн гэж үзжээ *(Зураг 4.22)*.

Дотоод орчныг тодорхойлогч үзүүлэлтүүдээр авч үзвэл Сүхбаатар, Булган аймгуудын бизнес эрхлэгчдэд ажиллах **хүчний нийлүүлэлт** бусад аймгуудтай харьцуулахад илүү хүндрэлтэй байгаа бол Архангай, Баян-Өлгий аймгуудад боломжийн гэсэн үнэлгээтэй байна. **Ажиллах хүчний ур чадварын** хувьд Сүхбаатар, Баянхонгор, Хэнтий, Булган аймгууд хүндрэлтэй гэсэн хариултыг хамгийн их өгсөн бол бусад аймгуудад ойролцоо түвшинд бага зэрэг хүндрэлтэй гэж үзжээ.

Сүхбаатар, Булган, Орхон, Говь-Алтай болон Улаанбаатар хотод бизнес эрхлэгчид **шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх** боломж бусад аймагтай харьцуулахад илүү хүндрэлтэй гэж үзэж байна. Харин Дорноговь, Архангай, Дорнод болон Дархан-Уул аймгуудын ЖДҮ эрхлэгчид боломжийн гэж хариулсан байна.

Барилга, байгууламжийн хүрэлцээ Говь-Алтай, Булган, Орхон аймгууд болон Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчдэд бага зэрэг хүндрэлтэй гэсэн бол Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл болон Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхлэгчид боломжийн гэж үнэлсэн байна.

Түүхий эдийн олдоцыг Говь-Алтай**,** Булган, Ховд, Завхан аймгууд болон Улаанбаатар хотод бизнес эрхлэгчид бага зэрэг хүндрэлтэй гэсэн хариултыг хамгийн их өгсөн бол бусад аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бараг хүндрэлгүй гэж дүгнэж байна.

Тоног төхөөрөмжийн чанар Булган, Говь-Алтай аймаг болон Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчдэд бага зэрэг хүндрэлтэй, бусад аймгуудын хувьд харьцангуй хүндрэлгүй гэж дүгнэж болохоор байна. Харин **өрсөлдөх чадварын** хувьд ихэнх аймгуудын бизнес эрхлэгчид хүндрэлгүй гэсэн хариултыг өгсөн байна (*Хүснэгт 4.6)*.

Хүснэгт 4.6 Дотоод орчин, үзүүлэлтээр *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*

	Ажилпах хүчний нийлүүлэлт	Ажилпах хүчний ур чадвар	Шинэ бүтээгэхүүн нэвтрүүлэх боломж	Барилга, байгууламжийн хүрэлцээ	Түүхий эдийн олдоц	Тоног төхөөрөмжийн чанар	Өрсөлдөх чадвар
Улсын дүн	**-0.40**	**-0.36**	**-0.23**	**-0.22**	**-0.18**	**-0.14**	**-0.10**
Архангай	-0.04	-0.22	0.00	-0.12	0.00	0.02	0.16
Баян-Өлгий	-0.06	-0.16	-0.26	-0.02	-0.08	0.00	0.13
Баянхонгор	-0.57	-0.61	-0.05	0.07	0.00	0.12	0.17
Булган	-0.73	-0.50	-0.41	-0.38	-0.35	-0.36	-0.30
Дархан-Уул	-0.31	-0.18	-0.05	-0.19	-0.06	-0.02	0.15
Дорнод	-0.30	-0.19	-0.02	-0.09	-0.04	0.08	0.21
Дорноговь	-0.31	-0.33	0.00	-0.05	0.05	0.00	0.20
Дундговь	-0.55	-0.41	-0.21	-0.22	-0.11	-0.08	-0.05
Говь-Алтай	-0.45	-0.46	-0.29	-0.43	-0.41	-0.29	-0.11
Говьсүмбэр	-0.23	-0.32	-0.23	-0.17	-0.03	-0.13	-0.07
Хэнтий	-0.49	-0.53	-0.23	-0.24	-0.05	0.07	0.00
Ховд	-0.33	-0.38	-0.32	-0.21	-0.30	-0.04	-0.04
Хөвсгөл	-0.20	-0.36	-0.12	0.00	0.13	0.10	0.18
Орхон	-0.50	-0.34	-0.30	-0.29	-0.19	-0.07	-0.09
Сэлэнгэ	-0.31	-0.24	-0.16	-0.14	-0.08	-0.02	0.20
Сүхбаатар	-0.70	-0.88	-0.43	-0.23	-0.10	0.00	-0.18
Төв	-0.50	-0.37	-0.23	-0.10	-0.17	-0.10	-0.10
Улаанбаатар	-0.42	-0.35	-0.29	-0.29	-0.25	-0.24	-0.21
Өмнөговь	-0.48	-0.22	0.27	0.02	0.11	0.33	0.25
Увс	-0.41	-0.27	-0.18	-0.12	-0.12	-0.10	-0.06
Өвөрхангай	-0.34	-0.34	-0.12	-0.20	-0.04	-0.16	-0.02
Завхан	-0.49	-0.46	-0.28	-0.19	-0.27	-0.04	-0.13

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчдэд дотоод үйл ажиллагааны нөхцөлийн хувьд ажиллах хүчний нийлүүлэлт, ажилчдын ур чадварыг бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн хүндрэлтэй гэж хариулсан нь аймаг нийслэлийн хэмжээнд ажлын байрны шаардлагыг хангах мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаар харуулж байна. Нийслэл хот болон зах зээлийн багтаамж харьцангуй багатай зарим аймгуудад бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж харьцангуй бага гэж хариулж байна. Харин өрсөлдөх чадвар, тоног төхөөрөмжийн чанарын хувьд аймаг, нийслэлийн хэмжээнд ерөнхийдөө боломжийн гэж үзэж байна.

4.8 Санхүүжилтийн орчин

Хөгжиж буй орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тулгардаг хамгийн гол бэрхшээл нь санхүүгийн дэмжлэгүүд байдаг[14]. Төрөөс ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээний хүрээнд 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр "Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль"-ийг батлан гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хуулийн 5 дугаар бүлгийн 15.1.4-т жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар тусгажээ. ЖДҮ эрхлэгчдийг Төрийн зүгээс дэмжиж, холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлсний үр дүнд ЖДҮ эрхлэгчид Төсөв (ЖДҮ-ийг хөгжүүлэх сан), Гадаад эх үүсвэр (ОУБ), Арилжааны банкны зээл зэрэг голлох 3 эх үүсвэрээс санхүүжиж байна.

Нэгдсэн дүн

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан түүвэр судалгааны үр дүнгээр санхүүжилтийн орчны индекс -0.57 гарсан бөгөөд ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчин төдийлөн сайнгүй байна гэж үзжээ. Энэ удаагийн судалгаагаар санхүүжилтийн орчин төдийлөн сайнгүй байна гэсэн үр дүн гарсан ч сүүлийн 2 судалгааны үр дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан үзүүлэлттэй байна.

Зураг 4.23 Санхүүжилтийн орчин *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Үүнд банкуудын ЖДҮ эрхлэгчдийн зээл сүүлийн хоёр жилд өссөн, мөн банкуудаар дамжуулан олгож буй засгийн газрын тусгай сангуудын дэмжлэг, олон улсын зах дээрээс босгосон "Чингис", "Самурай" бондын эх үүсвэрээр дотоодын үйлдвэржилтийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэржилтийн төслүүдийг санхүүжүүлж байгаа нь санхүүжилтийн орчин бага зэрэг сайжрахад нөлөөлсөн байх талтай.

[14] Дэлхийн банк: ОУСанхүүгийн корпорацын тайлан

Шигтгээ 4.11: Засгийн газраас үзүүлж буй санхүүжилтийн дэмжлэг

Засгийн газраас сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ЖДҮ эрхлэгчдийг дэмжих чиглэлээр бодлого, хөтөлбөрүүдийг ихээхэн хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд ЖДҮ эрхлэгчдэд зориулан багагүй хэмжээний хөнгөлөлттэй зээл, хүүний хөнгөлөлт зэрэг үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүүжилтийн дэмжлэгүүдийг үзүүлсээр ирсэн. Тухайлбал:

- 2006 онд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, үйлдвэрлэгчдийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-г байгуулсан.
- Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг орон нутагт хуваарилснаар эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, орон нутагт ЖДҮ-ийг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, зээлийн үр ашгийг дээшлүүлэх зорилготойгоор 2011 онд “Сум хөгжүүлэх сан”-г бий болгосон.
- Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах зорилгоор 2012 онд “Зээлийн батлан даалтын сан”-г үүсгэн байгуулсан.
- Хөгжлийн банкнаас “Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр бүхий Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд үйлдвэрээ өргөжүүлэхэд нь зориулан хөнгөлөлттэй зээлийг олгох замаар бизнесийг өргөжүүлэх, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэхэд, улс орны эдийн засагт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой төслийн санхүүжилтийг олгож байна.

Санхүүжилтийн орчны индексийг үзүүлэлтүүдээр нь авч үзвэл зээлийн хүү ЖДҮ эрхлэгчдэд хамгийн их хүндрэл болж байна.

Зураг 4.24 Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Түүний дараагаар зээлийн шимтгэл хураамж, зээлийн хугацаа, барьцаа хөрөнгө, зээлийн хэмжээ болон зээлийн батлан даалт оржээ.

Түүвэр судалгааны үр дүнгээр зээлийн хүүнд өгсөн үнэлгээ **(-0.71)** өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг муудсан үзүүлэлттэй байгаа бөгөөд бизнес

эрхлэхэд зээлийн хүү багагүй хүндрэл учруулж байна.

Зураг 4.25 Зээлийн хүү *(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа(2015)

Төв банкнаас мөнгөний бодлогоо хатууруулах чиглэлд арга хэмжээ авч 2014, 2015 онуудад бодлогын хүүгээ шат дараатайгаар өсгөсөн ба эдийн засгийн идэвхжил буурсан, валютын ханшийн хэлбэлзэл өндөр, эдийн засаг дах тодорхой бус байдал нэмэгдсэн зэрэг нь бизнесийн эрсдэлийг нэмэгдүүлж улмаар банкны зээлийн хүү өсөхөд нөлөөлсөн байх талтай.

Харин ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүү дунджаар жилийн 7-10 хувь, (*сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү жилийн 3%, ЖДҮ хөгжүүлэх сангийн зээлийн хүү жилийн 7-10%, бондын санхүүжилтээр олгож буй зээлийн хүү жилийн 9%*) олон улсын байгууллагуудын төслийн хөнгөлөлттэй зээлийн хүү 7-12%-тай байна.

Орон нутагт хөнгөлөлттэй зээлийн хуваарилалт төдийлөн сайн биш бөгөөд бизнес эрхлэгчид болон орон нутгийн хөгжил рүү гүйцэт чиглэхгүй байгаа талаар судалгаанд оролцогчид дурдаж байсан юм.

Хүснэгт 4.7 ОУ-н болон дотоодын эх үүсвэрээр олгож буй хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

	Зээлийн хүү	**Хугацаа**	**Хэмжээ**
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	9%	5 жил	ТШК*-н дэмжсэн дүн
Сум хөгжүүлэх сан	3%	5 жил	ТШК-н дэмжсэн дүн
Бондын санхүүжилтээр олгож буй зээл	9%	5 жил	2 тэрбум хүртэл
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	15%	1 жил	15 сая ₮ хүртэл
Бичил санхүүгийн хөгжлийн сан	30-19.2%	2 жил	15 сая ₮
ХХААЯ болон АҮЯ-тай хамтарсан “Ноолуур, ноос, сүү сүүн бүтээгдэхүүн, оёдол, хүлэмжийн аж ахуй байгуулах” хөнгөлөлттэй төслийн зээл	8%	2017 оны 12 сар хүртэл	ХХААЯ-аас тогтоосон дүн
АҮЯ-ы Арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээл	7%	5 жил хүртэлх	АҮЯ-аас тогтоосон дүн
ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээл	7%	10 жил	600,000 $
Дэлхийн банкны хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн зээл	6.61%	7 жил	600,000 $
АХБ-ны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төслийн зээл	12%	3-7 жил	600,000 $-3,000,000$
Германы KWF банкны төслийн зээл	15.8%	5 жил	250,000 евро
АХБ ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл	10%	2 жил	30 сая ₮

**ТШК (Төсөл шалгаруулах комисс)*

Мөн банкнаас зээл авахад тодорхой (шимтгэл 0.1-0.15%, хураамж 1000-15000₮) хувийг зээлийн шимтгэл, хураамж болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөрт авдаг нь хүндрэлтэй байдаг гэж ААН-үүд хариулжээ.

Шигтгээ 4.12: Зээл, зээлийн хүү

Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл

2015 оны I улирлын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 12.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 18% буюу 2.2 их наяд төгрөг нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд болон ААН-д олгосон зээл байна.

Эх үүсвэр: Монголбанк

Уг зээлийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг нийт 56.4 мянган иргэн болон 4.9 мянган ААН-үүдэд олгосон бөгөөд нэг зээлдэгчдэд ногдох дундаж зээлийн хэмжээ 36.5 сая төгрөг байна.

Зээлийн хүү

2009 оны хямралын үед макро эдийн засгийн орчин тогтворгүй болсон, Төв банкнаас бодлогын хүүг огцом нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалан зээлийн хүү 23.5% хүрсэн.

Хямралын дараах жилээс уул уурхайн салбарын эрчимтэй хөгжлийн нөлөөгөөр эдийн засгийн байдал сэргэж, Төв банкнаас мөнгөний зөөлөн бодлого баримталснаар зээлийн хүү 2011 онд 15.5 орчим хувь болж буурав.

2012 онд Засгийн газар, Төв банк хамтарсан хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй хөтөлбөрийн зээлийг ААН-үүдэд олгож эхэлсэн, түүний зэрэгцээ урт хугацаат, бага хүүтэй ипотекийн зээлийг 2013 оны хоёрдугаар хагасаас олгож эхэлсэн нь зээлийн хүү бага зэрэг буурахад нөлөөлөв.

Харин 2014 оноос эдийн засгийн байдал хүндэрч, макро эдийн засгийн орчны тогтворгүй бөгөөд тодорхой бус байдал нэмэгдсэн, Төв банкнаас мөнгөний бодлогоо хатууруулах чиглэлд арга хэмжээ авснаар зээлийн хүү өсөхөд нөлөөлжээ.

2015 оны I дүгээр улирлын байдлаар зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.03 функтээр өсч 19.1% (Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол зээлийн жигнэсэн дундаж хүү 17.6%)-тай байна.

Эх үүсвэр: Монголбанк

Харин орон нутагт олгогдож буй зээлийн жигнэсэн дундаж хүү улсын дунджаас 0.05 хувиар өндөр буюу 19.6% байна. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхлэгчдийн бизнес эрхлэх зардал өндөр, нөгөө талаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг банкуудын эх үүсвэрийн зардал өндөр байдагтай холбоотойгоор орон нутагт зээлийн хүү өндөр байна.



Орон нутаг дахь банкуудын зээлийн хүү аймаг тус бүрээр авч үзвэл Баян-Өлгий аймагт хамгийн өндөр буюу 22.3%, Дорноговь аймагт 22%, Завхан аймагт 21.1%-тай байгаа бол Өмнөговь, Говь-Алтай, Дорнод, Орхон аймгуудад бусад аймгуудаас харьцангуй бага буюу 18.2%, 17.7%, 17.5%, 16.6% тус тус байна.

ЖДҮ эрхлэгчид зээлийн хугацаа богино байгаа явдал нь хүндрэлтэй гэж үзсэн байна. Арилжааны банкууд урт хугацааны эх үүсвэр татаж чаддаггүй нь зээлийн хугацаа богино байхад голлон нөлөөлдөг. Банкууд урт хугацаатай бизнесийн зээл олгох нь тэдгээрийг хөрвөх чадварын эрсдэлд оруулж болзошгүй тул бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүжилт төдийлөн олгодоггүй байна. Банкны бизнесийн зээл ихэвчлэн 1-3 хүртэлх жилийн хугацаатай олгогддог бол төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл 5 болон түүнээс дээш жилийн хугацаатай олгогдож байна.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зээлийн хэмжээ төдийлөн хангалттай биш бөгөөд зээлд хамрагдахад зээлийн барьцаа хөрөнгө хүндрэлтэй байдаг гэж хариулсан байна. Түүнчлэн зээлийн батлан даалтад хамрагдах боломж бага байдаг ба зарим иргэд, ААН-н хувьд зээлийн батлан даалтын талаар төдийлөн ойлголтгүй байгаагаас үүдэн батлан даалтанд хамрагдаж чадахгүй байна.

Шигтгээ 4.13: Зээлийн батлан даалтын сан:

Монгол Улсын “ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ” хууль 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан. Уг хуулийн хүрээнд 10 дугаар сарын 29-ний өдөр Зээлийн Батлан Даалтын Санг үүсгэн байгуулахаар Засгийн газар, ТББ, Олон улсын байгууллагын төлөөлөл үүсгэн байгуулах санамж бичигт гарын үсэг зурав. 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Сангийн дүрэм батлагдсанаар ”Зээлийн Батлан Даалтын Сан“ үүсгэн байгуулагдсан.

Сангийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм.

Эрхэм зорилго: Шуурхай, ил тод, найдвартай үйлчилгээгээр Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, улмаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.

Зорилт:

- Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ;
- Иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангана;
- Сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулахад чиглэгдэнэ.

Батлан даалт гаргах үе шат:

1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч зээл хүссэн өргөдөл, зээлийн материалаа банк, санхүүгийн байгууллагад өгнө.
2. Банк, санхүүгийн байгууллага нь зээл олгох дүгнэлтээ Зээлийн батлан даалтын санд ирүүлнэ.
3. Зээлийн батлан даалтын сан ирүүлсэн материалыг нягтлан үзээд зөвшөөрвөл Зээлдэгч болон Банк, санхүүгийн байгууллагатай Батлан даалтын гэрээ байгуулна
4. Банк, санхүүгийн байгууллага нь Батлан даалтын гэрээнд үндэслэн батлан даалттай зээлийг олгоно.
5. Зээлдэгч нь батлан даалтын шимтгэл төлөхийг зөвшөөрнө.
6. Банк, санхүүгийн байгууллага нь батлан даалтын шимтгэлийг олгох зээлээс суутган Зээлийн батлан даалтын сангийн данс руу шилжүүлнэ

Зээлийн батлан даалтын мэдээ:



2015 оны 05-р сарын байдлаар зээлийн батлан даалтын сан нь нийт 59 тэрбум төгрөгийн зээлийн 40% буюу 24.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаад байна. Ингэснээр нийт 359 аж ахуй нэгж, иргэнд батлан даалт олгохоор шийдвэрлэсний үр дүнд төслөөр 1210 ажлын байр нэмэгдэх боломж бүрдэж байна.

Эх үүсвэр: Зээлийн батлан даалтын сан

Аймаг, нийслэлээр

Санхүүжилтийн орчны индексийг аймаг, нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Говь-Алтай, Ховд, Сүхбаатар, Хөвсгөл, Увс аймгуудаас санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчинд хамгийн муу үнэлгээ өгчээ. Харин Баян-Өлгий, Архангай, Дорнод зэрэг аймгууд санхүүжилтийн орчинг харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна.

Санхүүжилтийн орчинд хамгийн тааруу үнэлгээ өгсөн Говь-Алтай, Ховд аймгуудын ЖДҮ эрхлэгчид зээлийн хүү болон зээлийн шимтгэл, хураамж хамгийн хүндрэлтэй гэж хариулсан байна. Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын ЖДҮ эрхлэгчид мөн эдгээр хүндрэлүүдийг дурдсан.

Санхүүжилтийн орчинд боломжийн гэсэн үнэлгээг өгсөн Архангай, Дорнод аймгуудын хувьд зээлийн хугацаа болон хэмжээний хувьд харьцангуй боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.

Зураг 4.26 Санхүүжилтийн орчин, аймгуудаар
(-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн)



Эх үүсвэр:Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Дүгнэлт

Энэ удаагийн түүвэр судалгаагаар санхүүжилтийн орчинд өгсөн ЖДҮ эрхлэгчдийн үнэлгээ өнгөрсөн хоёр судалгааны дүнгээс (2012, 2014 он) бага зэрэг сайжирч эдийн засгийн халалттай үеийн (2011 он) түвшинд гарсан байна. Үүнд банкуудын ЖДҮ эрхлэгчдийн зээлийн хэмжээ өссөн, мөн банкуудаар

дамжин олгож буй Засгийн газрын “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-н болон бусад төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл нөлөөлсөн байх талтай.

Гэвч орон нутагт хөнгөлөлттэй зээлийн хуваарилалт төдийлөн сайн биш бөгөөд бизнес эрхлэгчид болон орон нутгийн хөгжил рүү гүйцэт чиглэхгүй байгаа талаар ЖДҮ эрхлэгчид дурьдаж байлаа.

Банкны зээлийн хүү макро эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдан төдийлөн буурахгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд ихээхэн хүндрэлтэй байна. Мөн банкнаас зээл авахад тодорхой хувийг зээлийн шимтгэл, хураамж болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөрт авдаг нь хүндрэлтэй байдаг гэж ААН-үүд хариулжээ.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зээлд хамрагдахад зээлийн барьцаа хөрөнгө хүндрэлтэй байдаг бөгөөд зээлийн батлан даалтад хамрагдах боломж бага байдаг гэж хариулсан бол зарим иргэд, ААН-н хувьд зээлийн батлан даалтын талаарх ойлголт бага байна.

5. ЗАРДЛЫН БАЙДАЛ

Үйлдвэрлэлийн үндсэн зардал: ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт зардлын 43.4%-ийг түүхий эд материал (22.7%), ажилчдын цалин (20.6%) буюу үндсэн зардал эзэлж байна. Төгрөгийн ханшийн сулралт нь түүхий эд материал болон тоног төхөөрөмжөө импортоор авдаг аж ахуй нэгжүүдэд ихээхэн хүндрэл учруулж байна.

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал: Нийт зардлын 34.3%-ийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд эзэлж байна. Үүнээс **хамгийн өндөр хувийг дулаан, ус** (6.5%)**, цахилгааны зардал** (6.3%) эзэлж байгаа бөгөөд энэ нь ААН-үүдэд багагүй хүндрэлийг бий болгож байна.

Үйл ажиллагааны үндсэн бус зардал: Зээлийн хүү (8.8%), шимтгэл хураамж (5.6%) буюу үйл ажиллагааны үндсэн бус зардал нь нийт зардлын 14.4%-ийг эзэлж байна. ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн олдоц төдийлөн хангалттай биш байгаагаас банкны өндөр хүүтэй зээлд хамрагддаг байна. Ингэснээр зээлийн хүүний зардал нь бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их дарамт болж байна. Түүнчлэн ЖДҮ эрхлэгчид банкнаас зээл авахад тодорхой хувийг зээлийн шимтгэл, хураамжийн төлбөрт төлдөг нь хүндрэлтэй байдаг гэжээ.

Үйл ажиллагааны зардал: Харин ЖДҮ эрхлэгчид нийт зардлынхаа 7.9 орчим хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байна.

Татвар, ашиг: ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт орлогынхоо 7.1%-ийг татварын зардалд зарцуулдаг бол 6.9% нь тухайн аж ахуй нэгжийн ашиг болдог байна.

ЗАРДЛЫН БАЙДАЛ

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс тайлан, тэнцэл гаргадаг эсэх талаар асуухад судалгаанд оролцсон нийт ААН-үүдийн 63% нь тийм гэсэн хариултыг өгсөн байна. Энэхүү бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад гарах зардлын байдлыг тогтоож, ямар зардал ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байгаа талаар авч үзсэн болно.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зардлын байдлын индекс **-1.11** буюу өмнөх жилүүдэд хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад хамгийн муу үзүүлэлттэй гарлаа. Энэ нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулахад гарч буй зардлууд нь ихээхэн хүндрэлтэй байгааг харуулж байна.

Зураг 5.1 Зардлын байдал *(-2=Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0=Хүндрэлгүй)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Зардлын бүлгийн индексийг үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэлтэй байна.

Түүний дараагаар шимтгэл хураамж, түүхий эд материалын зардал, тоног төхөөрөмжийн зардал, төрийн байгууллагын шимтгэл хураамжийн төлбөр, түрээсийн зардал, ажиллах хүчний зардал, дулаан, усны зардал, цахилгааны зардал, зам тээврийн зардал орж байна.

Харин үйл ажиллагааны зардал болон харилцаа холбооны зардал нь бусад зардлуудаас харьцангуй бага хүндрэлтэй гэж хариуллаа.

Зураг 5.2 Зардлын байдал, үзүүлэлтээр *(-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй)*

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

2015 оны 5 дугаар сарын байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.07 функтаар өсч 19.8% (Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол зээлийн жигнэсэн дундаж хүү 18.4%)-тай байна. Төв банкнаас мөнгөний бодлогоо хатууруулах чиглэлд арга хэмжээ авч 2014, 2015 онуудад бодлогын хүүгээ шат дараатайгаар өсгөсөн ба эдийн засгийн идэвхжил буурсан, валютын ханшийн хэлбэлзэл өндөр бөгөөд сулралт үргэлжилсэн хэвээр, эдийн засаг дахь тодорхой бус байдал нэмэгдсэн зэрэг нь бизнесийн эрсдэлийг нэмэгдүүлж улмаар банкны зээлийн хүү 2014 оны хоёрдугаар хагасаас эхлэн өсөхөд нөлөөлсөн байх талтай.

Зураг 5.3 Зээлийн хүү

Эх үүсвэр: Монголбанк

Банкны зээлийн хүү өсөх хандлагатай болсноор ЖДҮ эрхлэгчдийн хувьд зээлийн хүүний зардал ихээхэн хүндрэл учруулж байна. Энэхүү үр дүн нь санхүүжилт авахад хамгийн хүндрэлтэй нь зээлийн хүү гэсэн санхүүжилтийн орчины үр дүнтэй нийцтэй гарлаа.

ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн олдоц төдийлөн хангалттай биш байгаагаас банкны зээлд хамрагддаг байна. Банкны бизнесийн зээлийн хүү хөнгөлөлттэй зээлийн хүүнээс өндөр байдаг бөгөөд зээлийн хүүний төлбөр нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд ихээхэн дарамт болж байна.

ЖДҮ эрхлэгчид тусгай зөвшөөрөл, лиценз зэрэг төрийн байгууллагын шимтгэл, хураамж болон банкнаас зээл авахад тодорхой хувийг (шимтгэл 0.1-0.15%, өргөдлийн хураамж 5000-15000₮) шимтгэл, хураамжийн төлбөрт авдаг нь хүндрэлтэй байна гэжээ.

Зураг 5.4 Импорт ба валютын ханш

Эх үүсвэр: Монголбанк

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2012-2013 оныг хүртэл харьцангуй тогтвортой байсан бол 2013 оны сүүлийн хагасаас эхлэн огцом суларсан. 2014 оны эцэст 1 ам.доллар 1883 төгрөгтэй тэнцэж байсан бол 2015 оны 5 сарын байдлаар 1939 төгрөгтэй тэнцэж байна. Валютын ханшийн сулралт үргэлжилсээр байгаа ба хэлбэлзэл өндөртэй, тогтворгүй байдал нь түүхий эд материал болон тоног төхөөрөмжөө импортоор авдаг ААН-үүдэд ихээхэн хүндрэл учруулдаг байж болох юм.

Шигтгээ 5.1: Улаанбаатар хот болон орон нутаг дах ажилчдын цалин ба зарим бараа, бүтээгдэхүүний үнэ

Ажилчдын сарын дундаж цалин:

Аж ахуйн нэгжүүдийн сарын дундаж цалин 2015 оны I улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 11%-иар өсч 851.4 мянган төгрөг болсон байна.

Эх үүсвэр: УСХ

Сарын дундаж цалинг аймаг тус бүрээр авч үзвэл Орхон аймагт хамгийн өндөр буюу 1234.8 мянган төгрөг, Улаанбаатар хотод 925.3 мянган төгрөг, Өмнөговь аймагт 872.9 мянган төгрөг, Дорноговь аймагт 798.9 мянган төгрөг байгаа бол Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудад хамгийн бага буюу 596.3 мянган төгрөг, 586.0 мянган төгрөг тус тус байна.



Эх үүсвэр: УСХ

Цахилгааны үнэ:

Эрчим хүчний зохицуулах хорооны "Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам"-ын дагуу Цахилгаан эрчим хүч, дулааны үнийг нэмэгдүүлж Төв, Зүүн, Өмнөд, Алтай-Улиастай, Баруун бүсийн нэгдсэн сүлжээний хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний үнийг 2014 онд шинэчлэн батлсан. Ингэснээр цахилгааны үнэ 2014 оны 12 сараас эхлэн 9.85%-иар нэмэгдсэн байна.

Эх үүсвэр: УСХ

Орон нутагт 1кВТ.цаг цахилгааны үнэ дунджаар 87.0 төгрөг байна. Харин аймгуудын хувьд авч үзвэл Өмнөговь аймагт 1кВт.цаг цахилгааны үнэ хамгийн өндөр буюу 97.6 төгрөг, Сэлэнгэ аймагт 93.2 төгрөг, Архангай аймагт 92 төгрөг байгаа бол Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хамгийн бага буюу 75.9 төгрөг, 75.2 төгрөг, 73.9 төгрөг тус тус байна.



Эх үүсвэр: УСХ

Халаалтын үнэ:

2014 оны 12 сард дулааны үнийг 13%-иар нэмэгдүүлснээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж болон бусад байгууллагын 1мкв халаалтын үнэ 850 төгрөгт хүрсэн байна.

Эх үүсвэр: УСХ

Орон нутагт халаалтын үнэ харилцан адилгүй байгаа ба 1мкв халаалтын дундаж үнэ Сүхбаатар аймагт хамгийн өндөр буюу 1562.5 төгрөг, Говь-Алтай аймагт 1550 төгрөг байгаа бол Төв, Хөвсгөл аймгуудад дээрх аймгуудаас 2 дахин бага үнэтэй буюу 747.5 төгрөг, 700 төгрөг тус тус байна.



Эх үүсвэр: УСХ

Усны үнэ:

Улаанбаатар хот дахь цэвэр, бохир усны үнэ 2011 оноос хойш тогтвортой байсан бол 2014 оны 7 сараас эхлэн бохир усны үнэ 40%, цэвэр усны үнэ 47%-иар тус тус өссөн байна.

Эх үүсвэр: УСХ

Бензиний үнэ:

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2014 оны хоёрдугаар хагасаас эхлэн 50 орчим хувиар унаад байна. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны нийлүүлэлт харьцангуй тогтвортой байсан ч дэлхийн эдийн засгийн удаашралтай холбоотойгоор хөгжингүй болон хөгжиж буй орнуудын газрын тосны эрэлт буурсан, шатдаг занар, тосон элс, био түлш зэрэг шинэ төрлийн эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэн, ОПЕК зах зээлээ хадгалах бодлогод шилжиж, зорилтот үнийн бодлогоо орхисон зэрэг нь дэлхийн газрын тосны зах зээл дээрх үнэ буурахад нөлөөлжээ.



Засгийн газар, Монголбанкнаас гол нэрийн барааны үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд бензиний үнэ 2014 оны 5 сараас хойш харьцангуй тогтвортой болсон байна. Харин аймгуудын хувьд бензиний үнийг (АИ-92) авч үзвэл Ховд аймагт АИ-92 бензиний үнэ хамгийн өндөр буюу 2090 төгрөг, Говь-Алтай аймагт 2040 төгрөг, Завхан аймагт 2010 төгрөг, Увс аймагт 1940 төгрөг байгаа бол Орхон аймаг, Улаанбаатар хот, Дархан аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага буюу, 1660, 1660, 1646 төгрөг тус тус байна.



Эх үүсвэр: УСХ

Эрчим хүчний зохицуулах хорооноос 2014 оны эцэст цахилгаан, дулааны үнийг өсгөсөн нь цахилгаан, дулааны зардлыг нэмэгдүүлж улмаар ААН-үүдэд хүндрэл учруулж байна. Улаанбаатар хот болон аймгуудад цахилгаан, дулааны үнэ харилцан адилгүй байгаа бөгөөд зарим аймаг дах дулааны цахилгаан станц монополь байдлаа ашиглан өндөр үнэ тогтоодог нь бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл учруулж байгаа талаар түүвэр судалгаанд оролцогчид дурдаж байлаа.

Зам, тээврийг зардлыг тодорхойлогч гол хүчин зүйл болох бензиний үнэ нь Улаанбаатар хот болон хилийн боомтоос алслагдсан аймгуудад харьцангуй өндөр байдаг бөгөөд тус аймгуудын хувьд зам, тээврийн зардал өндөр байна.

Хэдийгээр дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ 2 дахин буурсан ч дотоодын бензиний үнэ тогтмол байгаа нь зам, тээврийн зардал төдийлөн буурахгүй байхад нөлөөлсөн.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт зардлынхаа хамгийн өндөр буюу 43.4 орчим хувийг үйлдвэрлэлийн үндсэн зардал болох цалин, түүхий эдийн зардалд зарцуулдаг байна.

Харин нийт зардлын 34.3 орчим хувийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал эзэлж байгаа бөгөөд үүнээс **дулаан, усны зардал, цахилгааны зардал хамгийн өндөр хувийг** буюу 6.5%, 6.3%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 5.5 Зардлын хуваарилалт

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын дараагаар үйл ажиллагааны (ҮА) үндсэн бус зардал буюу хүү, шимтгэлийн зардал ихээхэн хувийг эзэлж байна. Үүнд зээлийн хүүний зардал дунджаар 8.8%, шимтгэл, хураамжийн зардал дунджаар 5.6%-тай байна.

Түүнчлэн нийт зардлын хамгийн бага буюу 7.9 орчим хувийг үйл ажиллагааны зардалдаа зарцуулдаг байна.

ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт орлогынхоо 86 орчим хувийг үйлдвэрлэлийн үндсэн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал, үйл ажиллагааны зардал, үйл

ажиллагааны үндсэн бус зардлуудад, харин 7.1 орчим хувийг татварын зардалд тус тус зарцуулдаг бол үлдсэн 6.9 орчим хувь нь хуримтлал буюу ашиг болдог байна.

Аймаг, нийслэлээр

Зардлын байдлын индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Говь-Алтай аймагт хамгийн их хүндрэлтэй гарсан байна. Түүний дараагаар Ховд, Улаанбаатар хот, Булган, Төв аймгуудын ЖДҮ эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зардлын байдал их хүндрэлтэй байна гэж үзжээ.

Зардлын байдалд хамгийн тааруу үнэлгээ өгсөн Говь-Алтай, Ховд, Улаанбаатар хот, Булган, Төв аймгуудын хувьд зээлийн хүү болон шимтгэл, хураамж хамгийн хүндрэлтэй гэж хариулсан байна.

Харин Өмнөговь, Хэнтий аймгуудын ЖДҮ эрхлэгчдийн хувьд зардлын байдал хүндрэлтэй байна гэж хариулсан ч бусад аймгуудтай харьцуулахад бага байна.

Зураг 5.6 Зардлын байдал, аймгуудаар *(-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй)*



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2015)

Эдгээр аймгуудын хувьд мөн зээлийн хүү, зээлийн шимтгэл хураамжийн зардлыг хүндрэлтэй байна гэж үзжээ.

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчдийн хувьд дунджаар нийт орлогынхоо 86 орчим хувийг үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байна.

ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт зардлын 43.4%-ийг түүхий эд материал, ажилчдын цалин буюу үндсэн зардал эзэлж байна. Төгрөгийн ханшийн сулралт нь түүхий эд материал болон тоног төхөөрөмжөө импортоор авдаг аж ахуй нэгжүүдэд ихээхэн хүндрэл учруулж байна.

Нийт зардлын 34.3%-ийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд эзэлж байна. Үүнээс **хамгийн өндөр хувийг дулаан, ус, цахилгааны зардал** эзэлж байгаа бөгөөд энэ нь ААН-үүдэд багагүй хүндрэлийг бий болгож байна.

Зээлийн хүү, шимтгэл хураамж буюу үйл ажиллагааны үндсэн бус зардал нь нийт зардлын 14.4%-ийг эзэлж байна. ЖДҮ эрхлэгчид зээлийн хүү, зээлийн болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөр бизнесийн үйл ажиллагаанд ихээхэн дарамт болдог гэж үзжээ.

ЖДҮ эрхлэгчид нийт зардлынхаа 7.9 орчим хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байна.

Харин ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт орлогынхоо 7.1%-ийг татварын зардалд зарцуулдаг бол 6.9% нь тухайн аж ахуй нэгжийн ашиг болдог байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монголбанк “МЕК” ХХК-тай хамтран 2015 оны 6 дугаар сард ЖДҮ эрхлэгчдийн дунд “Монгол улс дахь ЖДҮ-ийн хөгжил, түүний санхүүжилт”-ийн талаар санал асуулга явуулж үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

Энэхүү судалгаанд нийслэл хотын бүх дүүргүүд болон 21 аймаг хамрагдсан бөгөөд нийт 1991 ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж (ХК, ХХК, нөхөрлөл, хоршоо), иргэд оролцов. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, дотоодын хөрөнгө оруулалттай, 1-9 хүртэлх ажилчидтай, 1-10 жил үйл ажиллагаа эрхэлж буй, жилийн 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН, иргэд байв.

Дэмжлэг үзүүлдэг байгууллагууд: Арилжааны банкууд, орон нутгийн засаг, захиргаа болон олон улсын байгууллагууд, Засгийн газар ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн болон санхүүжилтийн бус (сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа гэх мэт) тодорхой дэмжлэгүүдийг үзүүлж байна. Арилжааны банкууд хамгийн их санхүүжилтийг олгохын зэрэгцээ Засгийн газар болон ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нь арилжааны банкуудаар дамжин олгогддог тул ЖДҮ эрхлэгчид арилжааны банкыг хамгийн их дэмжлэг үзүүлдэг гэсэн хандлага өссөн байх талтай. Харин УИХ, Засгийн газрын хувьд зөвхөн санхүүжилтийн дэмжлэгээс гадна бодлого, үйл ажиллагаанд нь ЖДҮ эрхлэгчид ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс макро эдийн засаг нөлөө, нийгэм, улс төрийн байдал, хууль эрхзүй, төрийн зохицуулалт болон санхүүжилт орчин гол хүндрэл учруулж байна.

Макро эдийн засгийн нөлөө: Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь төгрөгийн ханшийн сулралт болон инфляци хамгийн муу нөлөөг үзүүлсэн гэж үзжээ. Сүүлийн жилүүдэд ГШХО оруулалт огцом татарч, экспортын гол барааны дэлхийн зах зээл дээрх үнэ буурч эхэлсэн нь манай улсыг төлбөрийн тэнцлийн хүндрэлд хүргэсэн. Улмаар энэхүү хүндрэл нь эдийн засагт төгрөгийн нэрлэсэн ханшийн сулралт, бодит эдийн засгийн өсөлтийн уналт хэлбэрээр илэрч байгаа нь иргэдийн худалдан авалт муудахад нөлөөлж ААН-ийн орлогыг бууруулах, нөгөөтэйгүүр ЖДҮ эрхлэгч нарын импортын түүхий эдийн (орц) зардлыг нэмэгдүүлэх дарамтыг үзүүлж байна.

Нийгэм, улс төрийн байдал: Санал асуулгын үр дүнгээс харахад ЖДҮ-ийн хөгжилд нийгмийн зүгээс учруулах хамгийн гол бэрхшээл нь ажилгүйдэл, ядуурал болж байна. Ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нэг талаас ядуурлын түвшинг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн худалдан авалтыг бууруулж байна. Үүнээс шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүйд хүрч, дунд хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлүүдтэй тулгарч эргээд банк, санхүүгийн салбарт хүндрэл учруулах талтай. Түүнчлэн улс

төрийн тогтворгүй байдал нь бизнес эрхлэгчдэд багагүй хүндрэл учруулж байна.

Хууль эрх зүй, төрийн зохицуулалт: ЖДҮ эрхлэгчдийн хувьд хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчинд өгсөн үнэлгээ судалгаа авч эхэлснээс хойш хамгийн муу түвшиндээ хүрсэн байна. Үүнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг төдийлөн хангалттай дагаж мөрдөхгүй байгаа, төрийн байгууллагын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэл ихтэй зэрэг нь голлон нөлөөлжээ. Мөн газар эзэмших боломжинд өгсөн үнэлгээ өмнөх судалгаанаас бага зэрэг буурсан дүнтэй байна. ААН, иргэдэд хэрэгцээний болон үйл ажиллагааны зориулалтаар газар өмчлүүлж байгаа хэдий ч газар олгох үйл явц, зохион байгуулалт тааруу мөн үйл ажиллагаа явуулахад тохиромжтой байршилд аж ахуйн зориулалтаар газар хувьчилж авах боломж бага байдаг нь хүндрэлтэй гэж үзэхэд нөлөөлжээ.

Зах зээлийн орчин: Судалгааны үр дүнгээр зах зээлийн орчин боломжийн гэсэн үнэлгээтэй гарсан ч өмнө судалгааны дүнгүүдээс эрс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд хэрэглэгчийн худалдан авах чадвар буурсан, зах зээлийн багтаамж хумигдсан нь голлон нөлөөлжээ. Эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилж, төгрөгийн ханш сулрах дарамт хэвээр байгаа, мөн ипотекийн зээлтэй иргэдийн хэрэглээ хумигдсан зэргээс шалтгаалан худалдан авалт буурсан нь бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж зах зээлийн багтаамж хумигдахад хүргэж байна. Харин технологийн дэвшил, мэдээллийн хүртээмж, зах зээлийн өрсөлдөөн зэрэг үзүүлэлтүүд харьцангуй боломжийн байна.

Дэд бүтцийн хөгжил: Бизнес эрхлэхэд чухал хүчин зүйлсийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. ЖДҮ эрхлэгчдийн дэд бүтцийн хөгжилд өгсөн үнэлгээ өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг муудсан хэдий ч бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн бүлгийн индексүүдтэй харьцуулахад хамгийн боломжийн гэсэн дүнтэй байна. Дэд бүтцийн хөгжлийг тодорхойлох үзүүлэлт тус бүрээр харвал зам тээвэр, дулаан усан хангамж бага зэрэг хүндрэлтэй байна. Харин цахилгаан түгээлт болон мэдээлэл холбооны хөгжил сайн гэсэн үнэлгээтэй гарлаа. Аймаг нийслэлээр авч үзвэл хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй төвөөс алслагдсан, баруун бүсийн аймгуудад дэд бүтцийн хөгжил бага зэрэг муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байна. Мөн Улаанбаатар хот болон төвийн бүсийн зарим аймгуудад ЖДҮ эрхлэгчид зам тээврийн асуудал бага зэрэг хүндрэлтэй бөгөөд шинээр зам барих болон засварын ажлын чанар хангалттай биш, хугацаа удаан, цаг үеэ олоогүй байдаг гэж үзжээ.

Дотоод үйл ажиллагаа: Дотоод үйл ажиллагааны нөхцөлийн хувьд ажиллах хүчний нийлүүлэлт, ажилчдын ур чадварыг бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага зэрэг хүндрэлтэй гэж ЖДҮ эрхлэгчид хариулсан нь улсын хэмжээнд ажлын байрны шаардлагыг хангах, нарийн мэргэжлийн, мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгааг харуулж байна. Нийслэл хотод болон зах зээлийн багтаамж харьцангуй багатай зарим аймгуудад бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж харьцангуй бага байна гэж хариулсан байна. Харин өрсөлдөх

чадвар, тоног төхөөрөмжийн чанарын хувьд ерөнхийдөө боломжийн гэж үзжээ.

Санхүүжилт: Манай улсад ЖДҮ эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь хөгжиж буй улсуудын нэгэн адил санхүүжилтийн асуудал юм. Энэ удаагийн түүвэр судалгаагаар санхүүжилтийн орчинд өгсөн ЖДҮ эрхлэгчдийн үнэлгээ өнгөрсөн хоёр судалгааны дүнгээс (2012, 2014 он) бага зэрэг сайжирч эдийн засгийн халалттай үеийн (2011 он) түвшинд гарсан байна. Үүнд банкуудын ЖДҮ эрхлэгчдийн зээлийн хэмжээ өссөн, мөн банкуудаар дамжин олгож буй Засгийн газрын төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл нөлөөлсөн байх талтай. Гэвч орон нутагт хөнгөлөлттэй зээлийн хуваарилалт төдийлөн сайн биш бөгөөд бизнес эрхлэгчид болон орон нутгийн хөгжил рүү гүйцэт чиглэхгүй байгаа сул тал ажиглагдлаа.

Банкны зээлийн хүү макро эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдан төдийлөн буурахгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд ихээхэн хүндрэлтэй байна. Мөн банкнаас зээл авахад тодорхой хувийг зээлийн шимтгэл, хураамж болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөрт авдаг нь хүндрэлтэй байдаг гэж ААН-үүд хариулжээ.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зээлд хамрагдахад зээлийн барьцаа хөрөнгө хүндрэлтэй байдаг бөгөөд зээлийн батлан даалтад хамрагдах боломж бага байдаг гэж хариулсан. Түүнчлэн зарим иргэд, ААН-ийн хувьд зээлийн батлан даалтын талаарх ойлголт бага байлаа.

Зардлын байдал: ЖДҮ эрхлэгчдийн нийт зардлын 43.4%-ийг түүхий эд материал, ажилчдын цалин буюу үндсэн зардал эзэлж байна. Төгрөгийн ханшийн сулралт нь түүхий эд материал болон тоног төхөөрөмжөө импортоор авдаг аж ахуй нэгжүүдэд ихээхэн хүндрэл учруулж байна.

Харин 34.3%-ийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд эзэлж байна. Үүнээс **хамгийн өндөр хувийг дулаан, ус** (6.5%)**, цахилгааны зардал** эзэлж байгаа бөгөөд энэ нь ААН-үүдэд багагүй хүндрэлийг бий болгож байна. Цахилгаан, дулааны үнэ ЖДҮ эрхлэгчдэд багагүй хүндрэл учруулж байгаа бөгөөд зарим аймаг дахь дулааны цахилгаан станц нь монополь байдлаа ашиглан өндөр үнэ тогтоодог талаар түүвэр судалгаанд оролцогчид дурдаж байсан юм.

Зээлийн хүү, шимтгэл хураамж буюу үйл ажиллагааны үндсэн бус зардал нь нийт зардлын 14.4%-ийг эзэлж байна. ЖДҮ эрхлэгчид зээлийн хүү, зээлийн болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөр бизнесийн үйл ажиллагаанд ихээхэн дарамт болдог гэж үзсэн байна.

ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт орлогынхоо 86 орчим хувийг үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байна. Харин 7.1%-ийг татварын зардалд зарцуулдаг бол 6.9% нь тухайн аж ахуй нэгжийн ашиг болдог байна.

Ерөнхий дүгнэлт: Гадаадын шууд хөрөнгө оруулалт татарсан, экспортын гол түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан зэрэг гадаад орчны таагүй нөхцөл, үүнээс үүдэлтэй дотоод эдийн засгийн хямралын шинжтэй байдал,

банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хөгжил сул байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад гол бэрхшээл болж байна. Түүнчлэн төр, засаг, улс төрийн тогтворгүй байдал болон шийдвэрүүд нь нөлөөлж байна гэж ЖДҮ эрхлэгчид үзэж байна.

Иймд УИХ, Засгийн газрын зүгээс бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна. Үүнд:

- Нэг салбараас хараат байдлыг бууруулах замаар, эдийн засгийн бүтцийг өөрчлөх зорилт тавьж ажиллах,
- Төрийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд дунд, урт хугацаанд валютын ханшийн хэлбэлзлийг бууруулж тогтворжуулах, инфляцийг нам түвшинд тогтвортой барих,
- Эдийн засгийн тухайн нөхцөл байдалд (хямрал, халалт) тохирсон санхүү, эдийн засгийн бодлого баримтлах,
- Төр, хувийн хэвшлийн харилцааг хууль, журмын хүрээнд явуулж, хүнд суртал, чирэгдэлийг багасгах,
- Түүнчлэн орон нутагт бүсийн төвүүдийг байгуулж, зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх,
- Тухайн бүс, аймагт зам тээврийн болон цахилгаан, дулааны нэгдсэн сүлжээг бий болгох, шинээр зам барих болон засварын ажлыг чанартай, түргэн шуурхай хийж гүйцэтгэх
- Гадаад болон дотоодод нарийн мэргэжлийн, мэргэшсэн ур чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэх ажлыг бодлогоор дэмжих
- Газар хуваарилалтыг ил тод болгох, зохион байгуулалтыг сайжруулах,
- Төрийн болон санхүүгийн байгууллагын шимтгэл, хураамжийг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлага тулгарч байна.